

ГҮНЗГИЙ МЭД

MONGOLIAN ECONOMY

2015 оны 06 сар. №14 (093)

www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ

Супер боломж супер түншлэл

БАНК САНХҮҮ

Цахиур хагалагчид айсуй

ЕРТӨНЦ

FIFA ба гэмт хэрэг

ТЭНЦВЭРГҮЙ ЗАХ ЗЭЭЛ

2%



ББСБ

1%



Даатгал

96%



Банк

1%




ХЗХ

0.3%



ҮЦЗЗ



МЭДЛЭГ
МЭДЭЭЛЭЛ
ИНФОГРАФИК
НИЙТЛЭЛ
ВИДЕО
ХАДГАЛАМЖ
ЭРСДЭЛ
ЗӨВЛӨГӨӨ
АШИГ
БАНК
МОНГОЛ
МӨНГӨ
АНХ
БИЗНЕС
УДАА
ХАРИЛЦАГЧ
ХАДГАЛАМЖ
ТӨСӨЛ
ТӨСӨВ
ХУВЬ ХҮН
ТӨЛӨВЛӨГӨӨ
ЗЭЭЛИЙН ХҮҮ
ӨРХИЙН САНХҮҮ

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН
ЦОГЦ САЙТ



www.golomtbank.com
ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД

БАНК
ЗЭЭЛ
ХУВЬЦАА
ХАДГАЛАМЖ
ХАРИЛЦАГЧ
МОНГОЛ
МӨНГӨ
АНХ
БИЗНЕС
УДАА
ХАДГАЛАМЖ
ТӨСӨЛ
ТӨСӨВ
ХУВЬ ХҮН
ТӨЛӨВЛӨГӨӨ
ЗЭЭЛИЙН ХҮҮ
ӨРХИЙН САНХҮҮ



ТАНЫ ЭЗГҮЙД

ХЭН ТАНЫ БАЙШИН, ҮНЭТ ЗҮЙЛС,
ЭД ХӨРӨНГИЙГ ХАРЖ ХАМГААЛДАГ ВЭ?

Харин **SHARP** брэндийн шинэ дэвшилтэт бүтээгдэхүүн болох **Smart Home Solution** Ухаалаг гэрийн хамгаалалтыг суурилуулснаар та итгэлтэйгээр гэрээ эзгүй орхиж болно. Та гэр болон бизнесийг хамгаалах шинэ үүлэн технологи бүхий хамгаалалтын систем танд амар амгалан, аюулгүй байдлыг бий болгоно.

УХААЛАГ ХАМГААЛАЛТ

- Хамгаална
- Бичлэг хийнэ
- Хэрэглэгчид мэдэгдэл илгээнэ

ХЯЛБАР ХЭРЭГЛЭЭ



Холбо Идэвхижүүл Тоглуул

ОЛОН ХАМГААЛАЛТ, ОЛОН ХЭРЭГЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хөдөлгөөн илэрсэн даруйд 30 секунд хүртэл хугацаатай бичлэг хийж, хэрэглэгчид мэдэгдэл хүргүүлэх болно.

ӨРГӨТГӨХ БОЛОМЖ



Нэмэлт камер, дохиолуудыг QR кодыг уншуулаад нэмж ашиглах боломжтой.

SMART HOME SOLUTION



9902-7699



Онлайн худалдаа:
www.pc-mall.mn

SHARP

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.БЭХБАЯР / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.ҮҮРИЙНТУЯА

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.ТҮВШИН

ВЭБ РЕДАКТОР:

Б.ЭНХЦЭЦЭГ

СЭТГҮҮЛЧИД:

А.БҮРЭНЖАРГАЛ

Г.ОРХОН

Э.ЗОРИТ

Ц.ЭЛБЭГСАЙХАН

ДИЗАЙНЕР:

С.ЭРДЭНЭЦОГ

ОРЧУУЛАГЧ:

Б.ЭНХМӨНХ

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904

Ч.ҮҮРИЙНТУЯА / 9409 2905

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

1 хороо, Энхтайвны өргөн чөлөө.

Экспресс тауэр. 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

Утас/Факс: 976 - 7011 5476

"Улаанбаатар Принт" ХХК-д хэвлэв

WWW.UBPRINT.MN

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантулхуур" номын дэлгүүр

"Номин" супермаркетиin бүх салбар

"Макс" супермаркетиin бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"GRAND PLAZA"

"METRO MALL"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр

"Max mall" дэх салбарууд

ЗАХИАЛГЫН ҮНЭ:

НЭГ ДУГААР

15,000₮

УЛИРАЛ /6 ДУГААР/

90,000₮

ХАГАС ЖИЛ /12 ДУГААР/

180,000₮

ЖИЛ /24 ДУГААР/

360,000₮

БОРЛУУЛАЛТЫН ҮНЭ:

180,000₮



ЭДИЙН ЗАСАГ

12 СУПЕР БОЛОМЖ СУПЕР ТҮНШЛЭЛ

14 БОДЛОГО,ҮР ДҮН

15 МОНГОЛ УЛС ЭРЧИМ ХҮЧНИЙ УУРХАЙ

16 Б.ЛАКШМИ: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЭДИЙН ЗАСАГ МУУ БАЙХ НЬ ХАМААГҮЙ ТОГТВОРТОЙ БАЙХ НЬ ЧУХАЛ

18 АСУУЛТЫН ТЭМДГИЙГ АНХААРЛЫНХ БОЛГОЁ



УУЛУУРХАЙ

22 ШИНЭ ЭХЛЭЛ БА ШАРЫН ГОЛ

БАНК САНХҮҮ

26 ЦАХИУР ХАГАЛАГЧИД АЙСУЙ

28 Д.АНГАР: ХӨРӨНГИЙН БИРЖИЙГ ХӨДӨЛГӨХ ТӨРИЙН БОДЛОГО ШААРДЛАГАТАЙ БАЙНА

34 БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

36 БАРИЛГА ӨНӨӨДӨР

39 ТӨМӨР ЗАМЫН ХӨГЖИЛ



ЕРТӨНЦ

40 ФИФА БА ГЭМТ ХЭРЭГ





ТА ӨӨРИЙН ГЭР БҮЛ,
ҮР ХҮҮХЭД, ӨМЧ ХӨРӨНГӨ,
БИЗНЕСИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД
САНАА ЗОВИНОДОГ УУ?

ТЭГВЭЛ ОРОН ЗАЙ ЦАГ ХУГАЦААГ ҮЛ ХАМААРАН БҮХНИЙГ ХЯНАХ
БОЛОМЖИЙГ “ДУВАСОХОР НД” КЛОУД КАМЕР ТАНЬД ОЛГОЖ БАЙНА



HD 720p Дуу болон Дүрсийг HD чанартайгаар дамжуулна

 Камерны чанга яригчийг ашиглан харилцан ярилцах боломжтой

 Univision, Skymedia болон бусад бүх төрлийн интернэт түгээгчийн WiFi төхөөрөмжтэй шууд зохицон ажиллана



WiFi болон 3G холболттой бүх төрлийн төхөөрөмжөөс хянах боломжтой



7-30 хоногийн бичлэг хадгалах клоуд үйлчилгээг камер тус бүрт сонгон хэрэглэнэ



Таны эзгүйд хөдөлгөөн илэрсэн тохиолдолд гар утас руу тань анхааруулах мессеж зургийн хамтаар илгээнэ



Та нэмж бичлэгийн төхөөрөмж, хард диск, хяналтын компьютер, статик IP хаяг зэргийг худалдан авах шаардлагагүй ба мэргэжлийн угсралт суурилуулалт, техникийн үйлчилгээ, хөглөрсөн утас кабельгүйгээр хүссэн газраа суурилуулан мөн зөөж ашиглах боломжтой

“ДУВА СОХОР НД” КЛОУД КАМЕР: **250 000₮**

MONGOLIAN ECONOMY СЭТГҮҮЛИЙН УНШИГЧДАД ТУСГАЙ БЭЛЭГ

LIVE UB.MN
Cloud video surveillance

Вэб: www.liveub.mn
Facebook: www.facebook.com/www.liveub.mn
Утас: 94242564
И-мэйл: info@liveub.mn


50 000₮



SOYOL
Wellness Center

МОНГОЛЫН АНХНЫ ВЭЛНЕСС ТӨВ

Улзуу Сайхнаар Амар



УТАС: 77009966
ВЕБСАЙТ: WWW.SOYOL.MN

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөний нийлүүлэлт энэ оны тавдугаар сард 9.8 их наяд төгрөг болж өмнөх сараас 134.5 тэрбум төгрөг буюу 1.4 хувь, өмнөх оны мөн үеэс 401 тэрбум төгрөг буюу 3.9 хувиар буурчээ. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 793.7 тэрбум төгрөг болж өмнөх сараас 58.8 тэрбум төгрөг өссөн бол банкуудын харилцах хадгаламж өмнөх сараас 145.8 тэрбум төгрөгөөр өсч, 1619.6 тэрбум төгрөгт хүрчээ. Зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт буурсаар байгаа бөгөөд Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл хоёрдугаар улирлын хурлаар макро эдийн засгийн төлөв, эдийн засагт гарсан өөрчлөлт, нөлөөллүүдийг хэлэлцэж буй. Сүүлийн сард инфляцийн түвшин буурч байгаа. Валютын ханш тогтворжих хандлагатай байгаа төдийгүй гадаад худалдааны ашиг нэмэгдсэн болон Оюутолгойн гүний уурхайн асуудал шийдэгдсэн эерэг мэдээлэл нь Төвбанкны бодлогын хүү болох 13 хувийг бууруулах үндэслэл болж байгаа талаар Үндэсний статистикийн хорооноос гаргасан макро эдийн засгийн тоймд дурьджээ.

ТӨСӨВ

Төсвийн орлого бүрдүүлэлт 82.6 хувьтай байна. Төсвийн алдагдал өсөх төлөвтэй байгаа бөгөөд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцэл тавдугаар сард 347.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөснөөс 670.7 тэрбум төгрөгөөр бага гарчээ. Гүйцэтгэлийн хувьд төсвийн орлого бүрдүүлэлт 82.6 хувь, зарлага 68.7 хувьтай байна. Сангийн яамнаас оны эцэст төсвийн орлого 400-500 тэрбум төгрөгөөр тасрах магадлалтай гэж тооцоолж байна.

ВАЛЮТЫН ХАНШ

Төгрөгийн ханш гадаад валютуудын эсрэг чангарч эхэллээ. Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2015 оны тавдугаар сард 1939.5 төгрөг болжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс долоон хувь суларсан үзүүлэлт аж. Гадаад валютын албан нөөцийн хэмжээ энэ оны дөрөвдүгээр сарын мэдээгээр 1267.3 сая ам.доллар байгаа нь өмнөх жилээс 43 хувиар буурсан дүн юм. Өнгөрсөн

сард Оюутолгойн гүний уурхайн гэрээ шийдэгдсэн нь хөрөнгө оруулалтын үрсгал нэмэгдэх боломж болсон.

ОРОН СУУЦ



Үл хөдлөх хөрөнгийн “Тэнхлэг зууч” компани энэ оны тавдугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг олон нийтэд танилцууллаа. Тус судалгаагаар орон сууцны үнэ тавдугаар сард 16.8 хувьтай гарчээ. Энэ нь өмнөх сараас 0.2 хувь өссөн үзүүлэлт аж. Харин оны эхэн үетэй харьцуулахад -1.8 хувь, өнгөрсөн оны мөн үетэй буюу 12 сарын өмнөхтэй харьцуулахад -5.4 хувиар буурсан байна. Шинэ орон сууцны үнийн индекс 26.7 хувьтай гарч, өмнөх сараас 0.4 хувиар буурсан байна. Хуучин орон сууцны индекс 10.0 хувьтай гарсан нь өмнөх сараас 0.6 хувь, оны эхэн үеэс 5.3 хувь, өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар буурсан үзүүлэлт аж.

ОЮУТОЛГОЙ


Монголын хөрөнгө оруулалтын банк болон “Ресорс инвестмент капитал” компани хамтран Монголын уул уурхайн салбарын судалгааг гаргажээ. Энэхүү судалгаа нь Оюутолгойн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтыг урагшлуулснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт хэрхэн нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд яаж нөлөөлөх талаар дүн шинжилгээ хийсэн цогц баримт болжээ.

Судалгааны тайланд Оюутолгой төслийн үр нөлөөг тооцоо-лохдоо гадны хөрөнгө оруулалт Оюутолгойн төслөөс шууд хамаарч байгааг онцолсон байна. Тус төслийн эхний үе шатаас хамааралтайгаар Монгол Улс дэлхийн хамгийн хурдацтай өсч буй эдийн засагтай орнуудын тоонд багтсан ч гадны хөрөнгө оруулалт Оюутолгой төслийн эхний шатны өмнөх түвшинд очсоныг тэмдэглэсэн байна. Монгол Улсын гадаадын хөрөнгө

оруулалт 2012-2014 онд 88.6 хувиар буюу 4.45 тэрбум ам.доллараас 0.5 тэрбум ам.доллар болтол буурсан ч тус уурхайтай холбоотой маргаантай асуудлуудаа шийдвэрлэснээр эдийн засаг хурдацтай өсөх хандлага бий аж. Монгол Улс руу шинэ хөрөнгө оруулагчдыг татаж, хөрөнгө босгох чадамжийг нэмэгдүүлнэ гэдгийг тус судалгааны үр дүн харуулж байна.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Үл хөдлөх хөрөнгийн зах зээл 2011 оноос өмнө төдийлөн идэвхтэй байгаагүй. Сүүлийн дөрвөн жилд 77 орчим оффисын барилга нийлэгдсэн нь идэвхжил нэмэгдсэнийг харуулж байна. “Мастер пропертис” компаниас Улаанбаатар хотын энэ оны дөрөвдүгээр сарын оффисын зах зээлийн судалгааг гаргажээ. Судалгаанд нийт 209 оффисын барилга хамрагдсан байна. Үүний дүнгээс үзэхэд зах зээл



дээр нийт 1078 сая мКв оффисын цэвэр талбай ашиглагдаж байгаа бол 2015 онд 26 оффисын барилгын 191.379 мКв талбай нийлүүлэгдэх төлөвтэй байна. Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар зах зээл дээр худалдах болон түрээслэх 169.229 мКв талбай хоосон байгаа нь нэг жил нийлүүлэгдэх хэмжээний оффисын талбай юм. Үүнийг эдийн засгийн таагүй нөхцөл байдалтай холбож болох аж. Хотын төвийн гурван дүүрэгт нийт оффисын 80 хувь нь байрлаж байгаа бол зэрэглэлээр нь авч үзвэл Улаанбаатар хотын оффисын зах зээлийн 14.3 хувь нь А зэрэглэлийн, 55.5 хувь нь В зэрэглэлийн, 30.6 хувь нь С зэрэглэлийн оффисын барилга байна.

Зах зээл дээр байгаа оффисын барилгын 77.4 хувийг түрээслэж байгаа бол үлдсэн 22.6 хувийг худалдаалж буй. Тус хугацаанд оффисын түрээсийн дундаж үнэ 32.607 төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеээс 30 хувиар буурсан үзүүлэлт.

ДЭЛХИЙД

САУДЫН АРАБ ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТНА



Саудын Арабын хөрөнгийн зах зээл гадаадын иргэдийг хязгаарлаж байсан түүхтэй боловч гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, газрын тосноос хараат байдлаа бууруулахын тулд холбогдох дүрэм журмаа сулруулж эхэллээ. Тус улсын Засгийн газрын орлогын 90 хувийг газрын тос бүрдүүлдэг бол сүүлийн үед газрын тосны ханш огцом унаж эхэлснээр гадаад валютын нөөцөө ихээр хэрэглэж буй. Одоогийн байдлаар доод тал нь таван тэрбум ам.долларын хөрөнгөтэй, дор хаяж таван жилийн туршлагатай байгууллагын хөрөнгө оруулагчид Саудын Арабт хөрөнгө оруулах эрхтэй болоод байгаа юм. Уг өөрчлөлтөөс өмнө гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн хувьцаа арилжааны сангаар дамжуулан Саудын Арабын хувьцааг худалдан авах боломжтой байжээ. Тэд зах зээлийн хэлбэлзлийг тогтворжуулах зорилгоор хөрөнгө оруулагчдыг урт хугацаагаар татах зорилготой байгаа юм.

Саудын Араб одоогийн байдлаар Сири болон Йементэй зөрчилтэй байгаа, мөн эдийн засгийг дэмжих багцын бодлогыг баримтлахаар төлөвлөж байна. Дээрх шалтгаанаас үүдэн 2014 онд үзүүлж байсан 3.6 хувийн эдийн засгийн өсөлт 2015 онд 2.5, 2016 онд 1.8 болж буурах төлөвтэй байна.

ОБАМАГ ӨӨРИЙНХ НЬ НАМ ЭСЭРГҮҮЦЭВ

АНУ-ын Төлөөлөгчдийн танхим дахь Бүгд найрамдах намынхан болон Ардчилсан намынхан Обамагийн Азид баримталж буй бодлогын хамгийн чухал хөтөлбөр болох Транс-Номхон далайн хамтын ажиллагааны худалдааны гэрээг дэмжсэнгүй. Хэрэв Конгресс Ерөнхийлөгчид уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрхийг өгвөл ирээдүйд заалтад өөрчлөлт оруулах эсвэл

шинэчлэлт хийх эрхгүй болох бөгөөд зөвхөн оруулж ирсэн гэрээнд тийм эсвэл үгүй гэж санал өгөх л эрх үлдэх аж. Ардчилсан нам Транс-Номхон далайн хамтын ажиллагааны гэрээний Хөдөлмөрийг дэмжих заалтыг эсэргүүцэж хөтөлбөрийг батлах асуудлыг хойшлуулсан. Хэдийгээр Төлөөлөгчдийн танхим болон Сенат аль аль нь хөтөлбөрийг баталсан боловч заалтууд өөр байсан учир эл асуудал хойшилсон юм. Ерөнхийлөгч Обама хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг авахын тулд хоёр танхимын гишүүд хуралдаж ялгаа гарсан асуудлуудад нэгдсэн шийдэлд хүрэх ёстой аж.



ШИНЭ ТОРГОНЫ ЗАМ

Синхуа агентлагийн мэдээлснээр БНХАУ Шинэ торгоны зам санаачлагын хүрээнд 16 тэрбум ам.долларын санг (100 тэрбум юань) алтны нөөц хуримтлуулах зорилготой байгуулахаар төлөвлөж байгаа гэв. Тус сан Шинэ торгоны замын гишүүн орнуудын банкуудад алт худалдаж авахад тус болох аж. Гишүүн орнуудын тоонд Энэтхэг улс багтаж байгаа юм. Хятад болон Энэтхэг улс дэлхийн алт үйлдвэрлэлийн тал хувийг эзэлдэг төдийгүй дэлхийн алтны хэрэглэний 80 хувийг бүрдүүлдэг. Шинэ торгоны замын дагуу алт олборлох боломжтой хэд хэдэн бүс нутаг байгаа бөгөөд тус сангийн гол зорилго алтны уул уурхайн төслүүд байх аж. БНХАУ дотоодын алтны зах зээлийг бий болгож алтыг юаниар үнэлэхээр төлөвлөж байна. Хятад улсын хэрэгжүүлэх эдгээр хөтөлбөр нь ам.долларын эдийн засагт эзлэх байр суурийг багасгах алхмуудын нэг юм. Зургаадугаар сарын 14-ний байдлаар нэг унци алт 1,181 ам.доллартай тэнцэж байна.

“УЙТГАРТАЙ” ХУВЬЦАА

АНУ-ын Эдийн засгийн судалгааны ашгийн бүс товчооны судалгаагаар

“уйтгартай” салбарт хөрөнгө оруулах нь илүү ашигтай сонголт гэжээ. Эдийн засгийн судалгааны үндэсний товчооны судлаачид аж ахуйн нэгжүүдийн ашгийн хуваарилалтыг судалсан байна. “Уйтгартай” салбар гэж илүү жигд ашгийн хуваарилттай салбаруудыг хэлсэн бол “сонирхолтой” салбар гэж жигд бус хуваарилттай салбаруудыг нэрэлжээ. Жишээ нь, Тесла эсвэл олон нийтийн мэдээлийн хэрэгслийн компанийн хувьцааг худалдаж авах нь илүү их хэмжээний ашгийг хурдан хугацаанд олох боломжтой ч энэ талаар ихэнх хүн мэддэг, мөн хувьцаа унаж эхэлвэл олсныхоо хэрээр алдах эрсдэл ихтэй аж. Уйтгартай гэгдэж буй салбаруудын талаар хүмүүс төдийлөн мэддэггүй мөн анхаардаггүй учир дутуу үнэлдэг, эдгээр салбарын хувьд эрсдэл багатай байдаг аж. Харин хөрөнгө оруулагчид уйтгартай салбар болон уналтад орсон салбарын ялгааг сайн таниж байж хөрөнгө оруулах хэрэгтэй хэмээн анхааруулж байна.

БАНКИРУУД

Английн банкны дарга Марк Карней Лондон хотын ёс зүйн талаар тавьсан илтгэлдээ хууль зөрчиж буй банкируудад илүү хатуу ял өгөх ёстой хэмээжээ. Карнейгийн үзэж буйгаар олон их наяд фунтийн гүйлгээг хийдэг Их Британийн хөрөнгийн зах зээл хуйвалдаан болон авлигад нэрвэгдсэн байна гэжээ. Тэрбээр “Хариуцлагагүй байх үе үгээр дуусах болно” гэсэн байна. Их Британийн сангийн сайд Жорж Осборн Карнейтай санал нэгдэж байгаагаа хэлээд томоохон хэрэгт холбогдсон этгээдүүдэд ногдуулж буй албадан хорих хугацаа хангалтгүй байгаа гэв. Английн банк болон Их Британийн Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгт холбогдож буй банкируудад илүү хүнд шийтгэл ногдуулах санал гаргажээ. Олон улсын санхүүгийн хэд хэдэн байгууллага гадаад валютын зах зээлд залилан хийж гэм буруутай нь тогтоогдсон бөгөөд долоон жил байсан хорих ялыг арван жил болгон нэмэх шийдвэрт хүрэх магадлалтай байгаа юм. ■



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

Хөрөнгө оруулалттай компаниуд:



Ердийн даатгал



Техник Технологийн
Дээд сургууль

Техникийн дээд
боловсрол, Коосэн



Брокер, дилер, андеррайтер,
хөрөнгө оруулалтын зөвлөх



Вэб сайт, маркетинг,
брэндинг



Санхүүгийн цогц
үйлчилгээ



Үл хөдлөх хөрөнгө



Урт хугацаат хадгаламж



Санхүүгийн программ
хангамж



Бичил санхүү

Хүчтэй. Хамтдаа.

Супер боломж Супер түншлэл



Б.Үүрийнтуяа

Ази Европт хэрэгтэй, Европ Азид хэрэгтэй. Ийм ч учраас АСЕМ буюу Ази, Европын орнуудын дээд хэмжээний анхдугаар уулзалтыг 1996 онд Тайланд улсад, Бангкок хотноо зохион байгуулж байжээ.

Анхдугаар уулзалтаас хойш өдгөө хоёр жил тутам болдог тус уулзалтын хамрах хүрээ өргөжин тэлж, хэдийнэ 51 улс, олон улсын хоёр томоохон байгууллага нэгдэж. Хоёр тивийн хооронд баригдаж буй “гүүр” гэж болохуйц АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалт нас залуу ч олон түүх бүтээх том арга хэмжээ хэмээн олон улсад хүлээн зөвшөөрөгдөх болсон. Улс төрийн, эдийн засгийн, нийгэм, соёл, боловсролын гэх үндсэн гурван багана бүхий тус чуулган тивүүд хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх, тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэн, зөвшилцөх, худалдаа хөрөнгө оруулалтын түншлэл бий болгох, мөн харилцан хүндлэл үзүүлэхийн зэрэгцээ үр дүн хүртэх платформ болдог учиртай.

Ази тивийн үсрэнгүй хөгжил өдгөө дэлхийн тренд болж буй. Түүгээр ч зогсохгүй олон улсын эдийн засгийн чигийг тодорхойлж байгаа гэхэд хилсдэхгүй. Үүний нэг хэмжүүр бол

дэлхийн томоохон эдийн засгуудын “гэр” Ази тивийн хүн амын дийлэнх хувь ядуурлаас асар хурдтай ангижирч буй гэсэн олон улсын судалгааны байгууллагын дүнг өнгөрсөн удаагийн уулзалтаар онцолсон байдаг. Улс төрийн нөлөөлөл, ноёрхлын хувьд ч Ази өөрийн байр сууриа эзэлж эхэлсэн талаар дурьдсан байна. Мөн Европын чөлөөт худалдааны гол түнш болсноор Ази Европын гадаад хөрөнгө оруулалтын урсгалын 26 гаруй хувийг өөрт татаж чадсан юм. Энэ нь 500 сая хэрэглэгч бүхий зах зээлийг хангах томоохон боломж.


Европт нэг хүнд ногдох ДНБ 25 мянган евротой дүйх тул дэлхийн хамгийн том эдийн засагтай тив. Энэ утгаараа тус зах зээлд нэвтрэх нь Азийн ирээдүйн өсөлтөд нөлөөлөх асар том түлхэц ажээ. Нөгөөтэйгүүр, Европын өсөлт Азийн тогтвортой хөгжлөөс хараат байна. Иймд хамтран нэгдсэнээр дэлхийн ДНБ-ий тал хувийг бүрдүүлэх АСЕМ-ийнхан дэлхийн нийт хүн амын 60-аас илүү хувийг бүрдүүлэхийн зэрэгцээ олон улсын худалдааны 60 хувийг мөн бүрдүүлэх аж.

АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтыг улс төрийн тэргүүд уулзаж л байдаг

улиг болсон чуулгануудыг нэг гэж боломгүй. Учир нь тэнд Ази, Европын орнуудын төлөөлөгчид дипломат харилцаа үүсгэхийн сацуу эдийн засгийн боломжуудын талаар олон өнцгөөс хэлэлцэх мөч тохиодог нь онцлог. Ингэхдээ тивүүд хоорондын бизнесийн орчныг сайжруулахад чиглэх чухал асуудлуудыг хөндөх бөгөөд санхүүгийн салбарт нэвтрүүлэх инновацилаг санаануудыг дэвшүүлэн, хэрэгжүүлэхэд анхаардаг аж.

Түүнчлэн эдийн засгийн өсөлтийг дэмжих үүднээс худалдаа болон хөрөнгө оруулалтад саад болдог хүчин зүйлсийг бууруулах, санхүүгийн болон нийгмийн салбарт бодлогын реформ хийх, мэдээлэл технологийн эдийн засаг дахь үүргийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хөндөн чуулдаг билээ. Одоогийн статистикаар АСЕМ-ийн хүрээнд эдийн засгийн салбарт 51 санаачлага хэрэгжиж буй манай улсад зохион байгуулагдах 11 дэх удаагийн АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлын албаны дарга Д.Ганхуяг дурьдсан.

Ирэх жил болох уулзалтыг манай улс даргалах үүрэг хүлээгээд буй. Энэ хүрээнд ч холбогдох ажлын хэсгүүд



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж АСЕМ-ийн 10 дахь удаагийн дээд хэмжээний уулзалт дээр, Итали улс Милан хот

байгуулагдаж, оногдсон ажил үүргээ гүйцэтгэж байна. Монгол Улс 2008 онд урд хөршийн нийслэлд зохион байгуулагдсан долоо дахь удаагийн уулзалтад оролцож АСЕМ-ийн гишүүн орон болж байсан.

Энэ уулзалтыг манай улс даргалах болсонтой холбоотой эерэг, сөрөг олон мэдээлэл тархаж буй ч эх орны эдийн засагт хэрхэх талаар бодит мэдээлэл алга. Энэ талаар холбогдох албанынхны онцолж буйгаар зохион байгуулагч орон бүтээн байгуулалтын ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх, татах, үйлчилгээний олон улсын стандарт нэвтрүүлэх, мөн дэд бүтцээ сайжруулах зэргийг хийхийн зэрэгцээ шаардлагатай салбаруудад сургалт, семинар зохион байгуулах гэх мэт шууд бус хөрөнгө оруулалт давхар хийдэг аж. Өөрөөр хэлбэл, АСЕМ-ийг зохион байгуулах нь улс орныхоо хөгжлийг “шинэчлэх” мотиваци болдог гэнэ.

Энэ хэрээр тухайн орныг зорих гадаад гийчдийн тоо нэмэгдэж, тэр хэрээр дотоодын эдийн засагт өсөлт мэдрэгддэг байна. Дэлхийн хэмжээний арга хэмжээ

амжилттай зохион байгуулна гэдэг нэр төрийн хэрэг. Тэр ч бүү хэл олон улсад итгэл түгээх томоохон хөшүүрэг. Өдгөө манай эдийн засгийн байдал сайнгүй байгаагийн зэрэгцээ манайхыг чиглэх гадаадын хөрөнгө оруулалт их хэмжээгээр тасраад буй.

Азид буй асар том боломж гэгдэх Монгол Улс өөрийн нөөц бололцоогоо дэлхийд ахин таниулах чухал үе ирэх


онд тохионо. Европын Холбооны зүгээс Ази тивтэй түншилж буйг талархан хүлээж авч байгаа бөгөөд энэ харилцаанд супер хүч биш супер түнш болох зорилготой буйгаа илэрхийлсэн.

Тэгвэл европчуудын супер гэж харж буй Ази тивийн “hyper” боломжууд зөвхөн Монголд бийг АСЕМ-ийн 11 дэх удаагийн уулзалтаар нотлох хэрэгтэй болох нь ээ. ■



Бодлого, үр дүн

Ц.Сайхан



Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар Төвбанкны гадаад валютын албан нөөц 1267.3 сая ам.доллар байна. Энэ нь өмнөх сараасаа 4.3 хувь, оны эхнээс 23.2 хувь, өнгөрсөн оны дөрөвдүгээр сартай харьцуулахад 30.4 хувиар буурсан дүн. Ам.доллар хомсдох болсон шалтгаан нь гадаадын хөрөнгө оруулалт буурсантай шууд холбоотой гэдэг. 2012 онд манай улсад дөрвөн тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн нь хорогдсоор энэ оны эхний улирлын байдлаар хасах 100 сая ам.доллар хүрчээ. Ам.долларын орох урсгал буурсан нь гадаад, дотоод хүчин зүйлээс хамааралтай. Нэг талаас Монголын хууль эрх зүйн орчин тогтворгүй, тодорхойгүйгээс гаднынхан хөрөнгө оруулахаасаа эмзэг болсон. Нөгөө талаас дэлхий нийтийн хөрөнгө оруулалт том зах зээл рүү чиглэсэн нь биднээс үл шалтгаалах хүчин зүйл байсан юм. Өмнө нь дэлхийн томоохон зах зээлүүд ханасан байдалтай байсан учраас жижиг зах зээлүүдийг хөрөнгө оруулагчид “шохоорхож” байжээ. Өнөөдөр дэлхийн эдийн засаг эргээд суларч буй тул АНУ болон бусад том зах зээлийг “сонирхох” болсон байна.

Яг энэ буцах урсгалын үетэй гол экспортын бүтээгдэхүүн нүүрсний үнэ буурсан нь нэрмээс болов. 2011 онд тонн тутам нь 130 ам.доллар хүрч байсан нүүрсний үнэ өнөөдөр 30 ам.доллар болтлоо буурсан нь төлбөрийн тэнцлийн алдагдалд оруулах үндсэн шалтгаан болсон. Тиймээс бодлогоо дотоодын аж ахуйн нэгжүүдэд дэмжихэд чиглүүлж мөнгөний нийлүүлэлтийг нэмж, бодлогын хүүг


бууруулсан. ДНБ-ий өсөлт 2012 онд 12.3, 2013 онд 11.6, өнгөрсөн онд 7.8 хувьтай гарсан. Үүнийг эдийн засгийг зөөлөн газардуулах сонголт хийсэн гэж тайлбарлаж байгаа. Энэ сонголтыг хийгээгүй бол 2009 онд Монголын эдийн засагт буй болсон үзэгдэл ахин давтагдах магадлал туйлын өндөр байсныг эдийн засагчид ярьдаг.

2008 оны арваннэгдүгээр сард 1100 төгрөгт эргэлдэж байсан ам.доллар 2009 оны гуравдугаар сард 1600 төгрөгт дөхөж ирсэн. Энэ үед гадаад валютын албан нөөц 521.4 сая ам.доллар болж 48.2 хувиар буурсан байна. Валютын хомсдлыг дагаад 2008 онд Улаанбаатар хотын инфляци 23 хувьд хүрэв. Гэтэл 2009 оны эцэст инфляци ердөө 1.9 болж буурчээ. Эдийн засгийн өсөлт 2008 онд 8.9 хувь байсан бол дараа жил нь -1.6 хувь болж хямарсан юм. Төлөв байдал муудаж, мөнгө болон зээлийн эрэлт буурснаар гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ нөөц мөнгөний өөрчлөлтийн 44 хувьтай тэнцэх хэмжээгээр буурсан байдаг. Шалтгаан нь Монгол Улс ОУВС-гийн “Стэнд бай” хөтөлбөрийг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой. Энэ хөтөлбөрийг авсан гэдэг нь Монгол Улс мөнгөний бодлогоо тус санд хүлээлгэн өгсөнтэй адил бөгөөд эдийн засгийг агшаах бодлого баримталдаг онцлогтой.

Ам.доллар 2012 оноос аажим өссөөр өнөөдрийн түвшинд хүрсэн юм. 2011 оны дөрөвдүгээр сарын 1-нд 1195 төгрөгтэй тэнцэж байсан ханш 1600 төгрөгийн босгыг давах хүртэл жил хагасыг үдсэн. Энэ хугацаанд инфляци хамгийн өндөртөө сард

14.9 хувь (өнгөрсөн оны долоодугаар сар) хүрч байв. Хэрэв энэ өсөлт 2008 онтой адил графикт зурагдсан бол эдийн засагт ямар дарамт учруулж, инфляци хэдэн хувь хүрэх байсныг бүү мэд. Харин өнгөрсөн сарын байдлаар инфляци найман хувь болж буураад байна. Ам.долларын ханш ч уруугаа чиглэжээ. Инфляцийн түвшин буурч эхэлсэн нь мөнгөний нийлүүлэлт саарч, өнгөрсөн оны долоодугаар сард бодлогын хүүг чангалсан үетэй давхцаж байгаа юм. Төвбанк бодлогын хүүг өнгөрсөн нэгдүгээр сард ахин нэмж 13 хувь хүргэсэн. Мөнгөний бодлогын зөвлөл дөрөвдүгээр сард хуралдахдаа энэ хэмжээг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн. Тус зөвлөл хамгийн сүүлд зургаадугаар сарын 9-нд хуралдсан. Тэд энэ оны эхнээс эдийн засагт гарсан эерэг өөрчлөлтүүд болон хоёрдугаар хагаст гарахаар хүлээгдэж байгаа нөлөөллүүдийг илүү дэлгэрүүлж задлах, загварын тооцооллуудыг дахин сайтар нягтлах, тэдгээрийг шинжилгээ, төсөөллийг, бодлогын саналд тусгахаар болсон байна. Шинэчилсэн төсөөлөл, шинжилгээг Мөнгөний бодлогын зөвлөлийн эцэслэн шийдвэр гаргаагүй байна. Ам.долларын ханшийн графикийг харахад энэ удаа огцом бус, алгуурхан буурч буй нь төгрөгийн ханш эргэн чангарах замдаа орсныг илтгэж байж ч болох юм. Харин Төвбанкны валютын нөөц ихээхэн багассан нь дотоодын зах зээл дээр гадаадын хөрөнгө оруулалт эргэлдэж байсан үетэй харьцуулснаас ингэж харагдаж буй ажээ. Түүнээс биш олон улсын жишиг, стандартад бүрэн нийцэж байгаа юм. ■

Монгол Улс эрчим хүчний уурхай



Нар

1200-1400
кВт/метр



Салхи

836.8 кВт.цаг



Ус

56.2 тэрбум
кВт.цаг



Занар

Нөөц - 788 тэрбум тонн
60 гаруйорд буй.
Нэг ам километр талбайгаас
шатахууныхаа 3 жилийн хэрэглээг,
Таван ам километр талбайгаас
30 жилийнхээ шатахууны
хэрэглээг хангана



Нефть

Нөөц - 2.4 тэрбум баррель
Өдөрт дунджаар 18000 баррель
газрын тос олборлодог,
Барэг бүгдийг экспорлодог



Нүүрс

Нөөц -173.3 тэрбум тонн,нөөц жилээс
жилд өсөн нэмэгдэж байна.
Эрчим хүчний нүүрс 100 тэрбум тонн
300 гаруй орд,илрэл байгаа



Уран

Нөөц - 126 мянган тонн /1.5 сая тонн болох боломжтой/
Ураны нөөц тогтооход Монгол орны нийт нутгийн 70 хувь хамрагдсан.
Дэлхийд 14 дүгээрт ордог.

Монгол Улсын эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нэг сая МВт

Б.Лакшми: Хөрөнгө оруулагчдад эдийн засаг муу байх нь хамаагүй тогтвортой байх нь л чухал

А.Бүрэнжаргал

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Эдийн засгийн форумын захирал, Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтын ерөнхий зохион байгуулагч Б.Лакшмитай ярилцлаа. Тэрбээр Холбооны бүгд найрамдах Герман улсын Берлин хот дахь Эдийн засаг, техникийн их сургуулийг Олон улсын менежмент, санхүүгийн чиглэлээр төгсчээ.

-Энэ жилийн бизнесийн дээд хэмжээний “Бизнес саммит 2015” чуулган өнгөрсөн жилийнхээс юугаар онцлог вэ?

-Монголын бизнесийн дээд хэмжээний уулзалтыг өнгөрсөн оны зургадугаар сард анх удаа зохион байгуулсан. Монголын эдийн засгийн форумар бид дотоод асуудлаа ярилцдаг. Харин хөрөнгө оруулалт татахад тусдаа үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй гэж үзсэн. Лондон, Хонконгод болдог Монголын хөрөнгө оруулалтын чуулганд гадаадын хөрөнгө оруулагчид очиж байгаа юм чинь Монголыг сонирхож байна гэсэн үг. Тэгэхээр тэнд харилцаа холбоо тогтоосон хүмүүсээ Монголд урьж хөрөнгө оруулалт татах, бизнесийхэнтэйгээ уулзуулах, бүтээн байгуулалтын ажлуудаа бодитоор танилцуулахын тулд энэхүү арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ жилийн хувьд эдийн засаг сайнгүй, хөрөнгө оруулагчдын итгэл суларсан үе л дээ.

Ийм үед хөрөнгө оруулалт татах янз бүрийн оролдлогууд хийх хэрэгтэй. Гаднын орнуудад Монгол Улсын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

Мэдээллийн хэрэгслүүдээр Оюутолгой гэж юу вэ гэдэг мэдээллийг л авч байгаа болохоос яг бодит байдал дээр ямар ч мэдээлэл алга. Дээрх нөхцөл байдлаас үүдэн чуулганыг зохион байгуулж байна.

-Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах ямар боломжууд байна вэ. Өнгөрсөн жилийн чуулганы үр дүн юу байв?

- Чуулган төр, хувийн хэвшлийн томоохон бүтээн байгуулалтын ажлуудын талаар хөрөнгө оруулагчдад танилцуулах, дэд бүтцийн томоохон гэрээнүүдэд гарын үсэг зурах, нэгдмэл байр сууртайгаар бизнесийн орчноо дэмжих зорилготой. Өнгөрсөн жил цахилгаан станцуудын төсөлд гарын үсэг зурсан. Тухайлбал, Тавантолгойн цахилгаан станцад хөрөнгө оруулах сонирхолтой байгаа хүмүүст төслийг танилцуулахын зэрэгцээ оролцогчдод бодит байдлыг тайлагнасан. Төслийн хувьд бүх зүйл бэлэн. Харин гацааж байгаа нь Оюутолгойгоос баталгаа авах. Мөн Тавдугаар цахилгаан станцыг барих Концессийн гэрээнд гарын үсэг зурсан. Хөрөнгө оруулагчид нь шалгарсан. Энэ бүхэн хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж байна.

-Энэ жилийн чуулганы үеэр ямар сэдвүүдийг онцолж байгаа вэ. Томоохон бүтээн байгуулалтын төслөө танилцуулж хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах ямар төлөвлөгөө байна вэ?

-“Эрдэнэт” үйлдвэр үйлдвэрлэлээ өргөжүүлж үйл ажиллагааныхаа хүчин чадлыг 25 хувиар нэмэгдүүлж байна. Мөн дампуурлын ирмэгт ирээд байсан

Шарын голын уурхай хувийн өмчид шилжиж гаднын хөрөнгө оруулалт татсанаар одоо ямар түвшинд ажиллаж байгааг бид мэднэ. Түүнчлэн хаягдал усыг дахин боловсруулах, “АСЕМ 2016” эдийн засагт ямар үр дүн үзүүлэхийг хэлэлцэнэ.

Уламжлал ёсоор мега төслүүд ба хөгжлийн явц гэсэн сэдэв бий. Монгол Улс асар их нөөцтэй орон гэж ярьж байгаа хэдий ч бид өнөөг хүртэл Тавдугаар цахилгаан станцын төслөө хэрэгжүүлж эхлээгүй байна. Энэ төсөл одоо эхлэхгүй бол 2020 он гэхэд улаанбаатарчууд цахилгаан, дулаангүй болно. Бид засвар үйлчилгээ гэдэг зүйлдээ анхаарч чаддаггүй. Гэнэт л болохоо байлаа гэдэг. Цэвэрлэх байгууламж ажиллахгүй бохируу Туул гол руу цутгаж байгаатай л адилхан. Цахилгаан станц барихад хэр хугацаа орох билээ. Үүнийгээ ч тооцоолохгүй байнга шийдвэрээ өөрчлөөд байвал хэн бидэнд итгэх билээ. Мөн манай улсын үл хөдлөх хөрөнгө, төмөр зам, дэд бүтэц, хөрөнгийн зах зээлийн талаар салбар хуралдаанууд болно. Ерөнхийдөө эдийн засгийн чухал салбаруудаа хэрхэн мөнгөжүүлэх талаар хэлэлцэх юм.

-Тэгвэл хүлээж байгаа үр дүнг хэрхэн харж байна вэ?

-Тавдугаар цахилгаан станцын эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурж эцэслэх төлөвлөгөөтэй байна. Мөн Шарын голоос Солонгос руу нүүрс экспортлох гэрээ хийнэ. Үр дүнгээ өгөх хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг хэлэлцэнэ.

Эдийн засгийн байдал хүнд байж болно. Гэхдээ энэ нь боломж

байхгүй гэсэн үг биш. Боломжоо хайж эрэлхийлэх хэрэгтэй. Аливаа зүйлийг хийж, бүтээж байж ашиг, үр дүн гарна шүү дээ. Чуулганы үеэр томоохон байгууллагуудаар танилцах аялал хийнэ. Өнгөрсөн жилийн хувьд Оюутолгой, Тавантолгой, МАК, АПУ, "Говь" компанитай танилцах аялал зохион байгуулсан. Энэ удаа "Эрдэнэт" үйлдвэр, "Эрдэнэт" хивс, бусад үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулахаар төлөвлөсөн. Учир нь зөвхөн Улаанбаатар хотод гэлтгүй хөдөө орон нутагт хөрөнгө оруулалт татах зорилготой. Эдийн засгаа төрөлжүүлбэ, төвлөрлөө сааруулья гэвэл бусад хот, аймагт хөрөнгө оруулалт татах нь бодит арга хэмжээ болох юм. Бид хөрөнгө оруул гээд уриалаад байдаг. Хамгийн гол нь тэр хүмүүст Монголд ирээд хаана, яаж хөрөнгө оруулах, мэдээллээ яаж авах зэрэг асуудал болдог. Түүнчлэн гадаадад байгаа Элчин сайдын яамдуудтайгаа уялдаа холбоо муу ажиллаж байна гэдэг.

Элчин сайдуудыг Монгол руу хөрөнгө оруулалт татсанаар нь ажлын үнэлгээг нь дүгнэх тухай ярьж байна. Энэ нь зөв. Хөрөнгө оруулагчдаа яг яаж холбох, хэрхэн уялдаа холбоотой ажиллах талаар хэлэлцэх утгаараа хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт илүү үр дүнтэй юм.

-Оюутолгойн гүний уурхайн санхүүжилтийн төлөвлөгөөнд гарын үсэг зурлаа. Хөрөнгө оруулагчдын хандлага сэргэнэ гэх хүлээлт байна. Зөвхөн уул уурхай бус өөр ямар салбарт хөрөнгө оруулах боломж бий вэ?

-Дараагийн томоохон мега төслүүдийг ажил хэрэг болгох боломж бидэнд бий. Хамгийн гол нь төслүүдийг улстөржүүлж байгаа нь асуудлыг улам дордуулдаг. Сонгууль болж өөр нам гарч ирэхээр өмнөх засгийн хийсэн ажлыг үгүйсгээд эхэлдэг. Том төслүүд ТЭЗҮ-ээ боловсруулахад их хугацаа зарцуулдаг. Үүний дараа хөрөнгө оруулалт татаад бүтээн байгуулалтын ажлаа эхлэх гэхээр өөр нам гарч ирээд орвонгоор нь эргүүлчихдэг. Миний харж байгаагаар үр өгөөжгүй зардал их гаргаж байна. Тавантолгойн уурхайд хичнээн ч тендер зарлав. Оролцогч компаниудын хувьд ч хөрөнгө мөнгө зарцуулж байгаа. "Seimens" компанийн

төлөөлөгч "Бид дөрвөн удаа тендер оролцсон. Ямар ч шийдэлд хүрээгүй" гэж байсан. Тэгэхээр дахиад оролцох эсэхдээ тэд эргэлзэж байх жишээтэй. Дэлхийн томоохон уул уурхайн компаниудын салбар Монголд байсан. Гэтэл одоо бүгдийг нь үргээсэн байна. Өөх ч биш булчирхай ч биш байхаар тэд залхаад явсан. Энэ жил гэхэд "Пийбоди" салбараа татлаа.

Одоо цөөн хэдэн компани үлдэж. Тэднийг авч үлдэх, төслүүдийг нь урагшлуулах тал дээр анхаарах хэрэгтэй. Манай улс хөгжихөд тийм хүнд биш. Бодлогоо зөв тодорхойлоод нэгдэхэд хөрөнгө оруулагчид бол бэлэн байна.

-Хөрөнгө оруулалтын чуулганд хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийнхний хамрах хүрээ хэр байна вэ?

-Хувийн хэвшлийнхний оролцоо идэвхтэй байгаа. Төслүүдээ танилцуулна. Хөрөнгө оруулагчдын хувьд 30 гаруй компани ирж байна. Эдгээрийн дийлэнх нь Америк байгаа бол Сангипур, Хонконг, Солонгос зэрэг улсаас мөн сонирхон ирж байна.

Хамгийн гол нь хөрөнгө оруулагчдад эдийн засаг муу байх нь хамаагүй. Тогтвортой байх нь л чухал. Засгийн газраас дахин бонд гаргах асуудал ярьж байна. Өрийг өрөөр дарж байгаа л нэг арга. Бид таван жилийн өртэй байсан бол арван жил болж байна гэсэн үг. Бид санхүүгийн бусад арга хэрэгсэл болох хөрөнгийн зах зээл бусад салбараа хөгжүүлэх боломтой. Амар хялбар аргаар биш дотоод орчноо сайжруулж, зээлийн хүүгээ бууруулах орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна.



Фотог: Б.Бямба-Очир

Дэлхийд мөнгө хангалттай их байна. Тэр мөнгийг татах боломж манайд бүрэн бий.

-Та жил бүрийн Эдийн засгийн чуулганыг зохион байгуулдаг. Энэхүү арга хэмжээний үр дүнгийн талаар тодруулбал?

-Монголын эдийн засгийн форумын үр дүнгийн талаар хүмүүс их асуудаг. Шууд утгаараа үр дүн гардаг гэж хэлэхгүй. Харин тус чуулганаар тулгамдсан зүйлээ ярилцаж нэгдсэн ойлголттой больё гэсэн давхар зорилго агуулдаг. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшил, иргэний нийгмийнхний дуу хоолойг сонсох суурь нь юм. Шинэ санаа дэвшүүлэх, хүмүүстэй уулзаж ярилцах боломж. Олон улсын байгууллагуудын зүгээс Монгол Улс бол жинхэнэ ардчилсан орон гэдэг. Сайд, дарга нар нь суугаад хүмүүс нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байна. Мөн Монгол Улс харьцангуй нээлттэй орон учраас асуудлыг ярьж, сонсож, хэлэлцүүлж байна. Энэ нь л форумын бас нэг онцлог юм. ■



СААРАЛ УС

Манай улсад нэг хунд ногдох усны нөөц хангайн бүсдээ дэлхийн дунджаас 4-5 дахин их байдаг. Харин говийн бүсэд 10 дахин бага.

Асуултын тэмдгийг анхаарлынх болгоё

Г.Орхон

Саарал усны талаар хэдэн жил ярих. Энэ нэр томъёо хүмүүст юуг хэлдэг нь асуултын тэмдэгтэй хэвээр байна. Тухайлбал, иргэн Б.Тулга “Хүнсний зүйлтэй хольж болохгүй дахин ашиглах ус” гэж байхад Г.Хулан “Төв цэвэрлэх байгууламжаас гарч байгаа ус юм биш үү” гэлээ. Тэгвэл иргэдийн зарим нь уул уурхайн салбарт дахин ашиглах эсвэл бүлингартаж бохирдсон усыг саарал гэж нэрлэж байна.

Саарал ус гэдэг нь ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус гэж Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.19-д заажээ. Энгийнээр хэлбэл, иргэн таны нүүр гар, хувцсаа угаасны дараах бохир усыг хэлж байгаа юм. Ойлголтын хувьд одоог хүртэл асуултын тэмдэгтэй байгаа саарал усыг цэвэршүүлж, дахин

хэрэглэх асуудлыг ажил хэрэг болгох талаар анхаарах хэрэгтэйг сануулах дохио дуугарч эхэлсэн. Гэвч өнөөдөр нийслэлд ахуйн хэрэглээнээс гарч буй бохир усыг цэвэршүүлэн дахин хэрэглэж байгаа газар хуруу дарам цөөн.

Саарал усыг цэвэрлэх технологи манайд төдийлэн сайн нэвтэрч чадаагүйг мэргэжилтнүүд хэлж байгаа. Одоогийн байдлаар цөөн тооны компани болон машин угаах газарт л цэвэрлэсэн усаа дахин ашиглаж байгаа талаар Ус сувгийн удирдах газрын дарга С.Үнэн ярилаа. Саарал усыг 96-97 хувьтай цэвэрлэдэг тул ахуйн бус зориулалтаар тухайлбал, үйлдвэрийн хөргөлт, гудамж талбайг угаах, услах зэрэгт хэрэглэх боломжтой гэдэг. Энэ ажил манайд боломж төдий яригдаж байхад Унгар, Польш тэргүүтэй дэлхийн бусад оронд

хэдийнэ хэвшил болжээ.

Усны газрынхны хувьд маш сайн цэвэрлэх байгууламж барьж, саарал, хар уснаас цэвэршүүлсэн ус гаргаж авах асуудлыг гол зорилтоо болгоод буй. Тухайлбал, “Ус” үндэсний хөтөлбөрт хаягдал бохир ус буюу саарал усыг цэвэрлэж унднаас бусад хэрэглээнд ашиглах талаар дэвшилт технологи нэвтрүүлэх зорилт тавьжээ.

Монгол Улсын хэмжээнд хог, бохир усыг цэвэрлэх нь асуудал болоод буй. Сүүлд Мэргэжлийн хяналтын газраас цэвэрлэх байгууламжуудад шалгалт хийхэд манай хот, хөдөөгийн бүх цэвэрлэх байгууламж “Шаардлага хангахгүй байна” гэх түн доогуур үнэлгээ авсан. Шалгалтаар эдгээр цэвэрлэх байгууламж бохир усны 60 гаруй хувийг л цэвэрлэж байгаа гэх

дүгнэлт гарчээ. Уг нь бол 90 гаруй хувьтай цэвэрлэх ёстой аж. Ер нь цэвэрлэх байгууламжийг сайжруулах ажилд хувийн хэвшлийнхэн гар бие оролцох хүсэлтэй байна. Тухайлбал, “Монгол Органик Ус” компанийн зүгээс бохир усыг цэвэрлэх эко буюу органик технологийг санал болгосон байна.

Одоогийн манайд хэрэглэж буй механик болон биологийн шүүлт хийн бохир усыг цэвэрлэж буй технологиос органик технологи нь нэмэлт органик шүүлт хийдгээрээ онцлог. Энэ нь өмнө шүүлт хийсэн усаа хоёроос гурван мянган төрлийн ургамал, загас, бичил биетийн тусламжтайгаар дахин шүүж, цэвэршүүлнэ гэсэн үг. Давуу тал нь манайд байгаа цэвэрлэх байгууламжуудаас гурав дахин бага талбайд, ямар ч үнэр гаргахгүйгээр цэвэрлэх гэнэ.

“Монгол Органик Ус” ХХК-ийн захирал Ө.Батболд “Улаанбаатарын цэвэрлэх байгууламж хаягдал лаг шавраа 44 га талбайд нүх ухаад булдаг. Энэ нь эвгүй үнэр ихтэй, гүний ус руу бохирдол нь нэвчиж, улмаар байгальд хор нөлөө үзүүлж байгаа юм. Хэдий одоогийн технологи эдийн засгийн хувьд хямд өртөгтэй ч байгаль орчинд хамгийн сүйтгэлтэй аргаар хог хаягдлаасаа салж байгаа хэрэг. Бид үүнийг дахин боловсруулаад бордоо, газ болгон дулаан, цахилгаан гаргах эко технологи нэвтрүүлэхээр ажиллаж байна” гэлээ. Тэд уг технологийг Унгар улсын “Органика” компанитай хамтран Монголд оруулж ирэхийг зорьж байгаа аж. Гэвч холбогдох албаныхан тодорхой мэдээлэл өгөхгүй байгаагаас үүдэн тэдний ажил урагшлахгүй хүлээгдсээр. “Бид хот байгуулалт, Нийслэлийн захиргаа зэрэг холбогдох байгууллагад албан бичиг өгөөд явж байна. Харамсалтай нь, бидэнд хангалттай мэдээлэл өгөхгүй байна” хэмээн “Монгол Органик Ус” ХХК-ийн захирал ярилаа. Тэд Нийслэлийн цэвэрлэх байгууламж дээр уг технологийг нэвтрүүлэхэд хамтарч ажиллах санал тавьсныг Ө.Батболд хэлсэн юм.

Энэхүү технологи нь дэлхийн зах зээл дээр сүүлийн 15 жилд эрэлт өндөртэй байгаа аж. Тухайлбал, Ази тивээс Энэтхэг, Хятадад нэвтэрсэн. Мөн Герман, Унгар, Польш болон Европын орнуудад хэрэглэдэг. Манайд ашиглаж

буй уламжлалт технологиос илүү урт настай бүтээн байгуулалт гэгддэг байна.

Бид цэвэр усыг ариг гамгүй хэрэглэж нойлын суултууртаа урсгаж, машинаа ч угаадаг. Энгийнээр хэлбэл Батын машин угаах үйлдвэрт, түүний гэр бүлийнхний гэр ахуйдаа хэрэглэсэн бохир усыг цэвэршүүлэн хэрэглэх боломжтой. Чимгээгийн хувцсаа угаасан усаар Бат машинаа угаадаг болчихвол бид усаа одоогийн хэрэглэж байгаагаас дор хаяж хоёр дахин хэмнэх боломжтой болох аж.

Ойлголтын хувьд одоог хүртэл асуултын тэмдэгтэй байгаа саарал усыг цэвэршүүлж, дахин хэрэглэх асуудлыг ажил хэрэг болгох талаар анхаарах хэрэгтэйг сануулах дохио дуугарч ЭХЭЛСЭН.

Өнөөдөр хотоос гарч буй бохир усыг Төв цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэн Туул гол руу шууд нийлүүлж байна. Бид яагаад бохир усаа цэвэршүүлж хэрэглэхгүй байгаа талаар Усны газрын орлогч дарга асан З.Батбаяр “Өнөөдөр ялангуяа, уул уурхайн компаниуд нэгэнт мөнгөө төлчихсэн юм чинь усыг яасан ч хамаагүй гэдэг байдлаар ханддаг.

Тэгвэл тийм биш ээ. Тухайн байгууллагын эцсийн бүтээгдэхүүнээс хэдий хэмжээний бохир ус гарч байна төдий хэмжээний төлбөр авна гэсэн зарчим байх ёстой. Нөөц болон эцсийн бохирдол дээр нь тус тусад нь төлбөр аваад эхэлбэл уул уурхайн компаниуд ус бохирдуулсны төлбөр төлөхгүйн тулд хяналттай, хариуцлагатай ажиллаж эхэлнэ. Усаа цэвэршүүлэх, цэвэршүүлсэн усаа дахин ашиглах технологийг нэвтрүүлж эхэлнэ. Өнөөдөр Монголд саарал ус гэдэг ойлголт байдаггүй, усыг дахин ашигладаггүй гол агуулга үүнд

байгаа юм. Энэ асуудлыг шийдсэнээр зөвхөн уул уурхай ч бус машин угаалгын газар, нойл гэх мэтэд бид цэвэр ус ашиглахаа болино” хэмээв.

Усны гамгүй хэрэглээний цаана усны нөөцийн асуудал хөндөгддөг. Дэлхийн цэвэр усны нөөц багасч буй өнөө үед манай улсын усны салбарынхан “Усаа хэмнэе” гэсээр сүүлийн хэдэн жилийг үдлээ. Үүний дүнд чамлаж үл болом үр дүн гарчээ.

Ус сувгийн удирдах газрын дарга С.Үнэн “Маш сайн үр дүн гарсан. Усны үнэ тариф нэмэгдээгүй байхад өнгөрсөн жилийн өдийд нийслэлд хоногт 165 мянган шоо метр ус хэрэглэж байсан бол одоо 145 боллоо. Нийслэлчүүд 20 мянган шоо метр ус хэмнээд эхэлж. Өнгөрсөн онд барилга их хэмжээгээр баригдаж, үйлдвэрүүд ч ажилласан. Хэдий манай борлуулалтын орлого огцом буурсан ч усны хувьд хэмнэлт гарсан” хэмээн онцоллоо. “Үүнд, ухуулга сурталчилгаа болон төвлөрсөн шугамд холболттой бүх газрын усны үнэ нэмэгдсэнээр хүмүүс хэмнэлтийн горимд орсон нь нөлөөлсөн” гэж С.Үнэн дарга тайлбарлав.

Нийслэлийн орон сууцны хэрэглэгчдийн хэрэглэж буй нэг литр цэвэр усыг 48 мөнгө, бохир усыг 24 мөнгө болгон нэмсэн. Гэхдээ энэ нь НӨАТ, нэмэлт зардал ороогүй үнэ. Орон сууцанд амьдардаг нэг өрх 2500, Налайх, Багануур, Төв аймагт оршин суудаг айлууд сар бүр 1860 төгрөгийн усны суурь хураамж төлж байгаа. Гэр хорооллын өрх нэг литр усанд нэг төгрөг төлж байна.

Сүүлийн таван жилд дэлхийн улс орнууд усныхаа үнийг тодорхой хэмжээгээр нэмсэн байгаа юм. Жишээлбэл, АНУ 27, Англи 32, Австрали 45, Канад 58 хувиар усны үнэ нэмэгдүүлсэн байх жишээтэй. Энэ нь эргээд жил ирэх тусам шавхагдаж буй ундны усаа хэмнэх гэсэн хүн төрөлхтний хичээл зүтгэл аж.

Манай улсын хувьд нэг хүнд ногдох усны нөөц Хангайн бүсдээ дэлхийн дунджаас 4-5 дахин их байдаг. Харин говийн бүсэд 10 дахин бага. Ийм нөхцөлд бид цэвэр усаараа туйлсаар байна. Усны нөөц, усны үнийг жигдлэх нь ч тодорхойгүй гээд усны асуудлаар өнөөдөр олон хариулт хүлээгдэж байна. ■

Хөрөнгө оруулалтын өгөөж 2014 онд

Л.Бямбаа /Эдийн засагч/

Гадаад,дотоодын ялгаагүй бүх хөрөнгө оруулагч нарын хувьд чухамхүү юунд хөрөнгө оруулах, ямар хугацаатай байршуулах, ямар өгөөж авах, тухайн хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь ямар эрсдэлтэй зэрэг нь хамгийн гол асуултууд байдаг.

Монголд хөрөнгө оруулалтыг татах, нэн ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдын валютын урсгалыг оруулж ирэх нь эдийн засагт тулгарч буй олон хүндрэлийг даван туулахад чухал

гэдгийг бүгд хүлээн зөвшөөрч байгаа. Гэхдээ ирээдүйд дан ганц гадаадын хөрөнгө оруулалтад найдсан шийдлүүд гаргавал өмнөх алдаануудаа давтсан хэрэг болно. Гадаадын хөрөнгө оруулагчдын мөнгөн урсгал, тэр дотроо уул уурхайн хөрөнгө оруулалтаас хараат, савалгаатай байдлыг бууруулах, эрсдэлийг багасгахын тулд үндэсний хуримтлал, хөрөнгө оруулалтыг дэмжих нь зүйтэй.


Монголд хөрөнгө оруулалтын сан,

хувийн тэтгэврийн санг хөгжүүлэх асуудал яригдахад эдгээр сангууд нь хөрөнгө оруулах хэрэгсэл байхгүй мэтээр тайлбарлах тохиолдол байдаг. Нөгөө талаас мөнгөн хуримтлал, сангууд нь байхгүй учир хөрөнгө оруулалтын хэрэгсэл хөгжихгүй байна ч гэдэг үзэл санаа бас гардаг. Бодитоор Монголын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын хэрэгслүүд олон байгаа ч, тэдгээрийн өгөөж 2014 онд төдийлөн сайнгүй байв.

Төвбанкны үнэт цаас (ТБҮЦ)

ТБҮЦ мөнгөний бодлогын чухал хэрэгсэл бөгөөд арилжааны банкуудад илүү хамаатай. Гэхдээ ТБҮЦ хүү нь төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлдэг учир өгөөжийн муруйн жишиг тогтооход тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 2014 онд 10.5-12 хувийн хооронд тогтсон байна.


ТБҮЦ, 7 хоногтой, ЖДХ, 2014 онд сараар



Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)

ЗГҮЦ хамгийн эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогддог бөгөөд хүү нь татвараас чөлөөлөгдөх орлогод тооцогддог тул цэвэр өгөөж өндөр байх давуу талтай. 12 долоо хоногтой үнэт цаасны купон 2014 онд ямар байсныг доорхи графикт үзүүлэв. Наймдугаар сараас эхлэн хүүгийн түвшин огцом нэмэгдсэн нь ажиглагдаж байна.

12 долоо хоногтой ТБҮЦ, ЖДХ, 2014 онд сараар




Эх сурвалж: Монголбанк

Засгийн газар 2014 онд жижиглэнгийн үнэт цаас гаргаж эхэлсэн нь хувь хүн, аж ахуйн нэгжид зориулсан хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд шинэ зах зээлийг бий болгосон гэж хэлж болно.

Алт

Алт буюу алтны данс банкуудад нээлгэж арилжаа хийх нь бас нэг хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд 2014 оны хувьд өгөөж харьцангуй өндөр байлаа. Жилийн турш алтны ханш 12 хувиар өссөн байна.

Алтны авах ханш, сарын эхэнд, төгрөг/гр




Эх сурвалж: Монголбанк

Үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ҮХХБҮЦ)

2014 онд Монголын Ипотекийн Корпораци үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг төрөл болох ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын хэд хэдэн удаагийн багц гаргаж банкуудад худалдсан. Хэтдээ институционал хөрөнгө оруулагчид энэ бондоос худалдаж авах бүрэн боломжтой. Давуу эрхтэй ИЗББ 4.5, харин энгийн ИЗББ нь 10.5 хувийн хүүтэй гарсан.

Банкуудын төгрөгийн хүү, 2014 онд



Банкны хадгаламж, хадгаламжийн сертификат

Банкны төгрөгийн болон валютын хадгаламж нь хамгийн түгээмэл хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд өгөөж хамгийн өндөр байна. Хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат нь ойролцоо боловч сүүлийнх нь үнэт цаас учир шилжүүлэх, барьцаалах, хэсэгчлэн худалдах боломжтойгоороо давуу талтай.

2014 онд долларын ханш чангарч байсан тул валютын хадгаламж хүү болон ханшийн өгөөж нийлээд 19-20 орчим хувь хүрсэн байна.

Банкуудын ам.долларын хүү, 2014 онд




Эх сурвалж: Монголбанк

Валют – ам.доллар

Ам.долларын 2014 оны эхний албан ханшийг оны төгсөлтэй харьцуулбал ам.доллар 13.6 хувиар чангарсан байна. Харин Хятадын юань жилийн дотор 10.7 хувиар чангарсан байна.

МОНГОЛБАНК - USD 2014.01.02 - 2015.01.02




Эх сурвалж: www.gogo.mn

Дүгнэлт

2014 оны хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт дараах байдалтай гарлаа. Жилийн инфляци 11 хувь байсан учир бодит өгөөж бүр ч бага байна. ■

Өгөөж 2014 онд, хувиар





СУРВАЛЖЛАГА

“Шарын голын уурхай нь Монголын нүүрсний аж үйлдвэрийг олон жил манлайлсан техник технологийн дэвшлийн шинэ үеийн уул уурхайн мэргэжилтэн бэлтгэдэг суурь мөн”

П.Очирбат /Монгол Улсын Ерөнхийлөгч асан/

Шинэ эхлэл ба Шарын гол

Ц.Элбэгсайхан

Дархан-Уул аймгийн Шарын гол сум Улаанбаатар хотоос 240 орчим, аймгийн төвөөс 70 орчим км зайтай. Сум гэхэд дэд бүтцийн хөгжил зарим аймгийн төвөөс ч илүү. Төмөр зам, өндөр хүчдэлийн шугамд холбогдсон, 7.2 гкал хүчин чадал бүхий бие даасан дулааны станцтай, 15 блок таван давхар орон сууцтай энэ сум өмнө нь “хот”-ын статустай байв. 9000 гаруй оршин суугчтай тус “хотод” өнөөдөр 2200 гаруй сурагчтай ерөнхий боловсролын хоёр сургууль, 350 хүүхдийн орон тоотой гурван ч цэцэрлэг бий. Сум ингэж бусдаасаа “тасархай” хөгжсөн нь 50 дахь жилийнхээ нүүрийг үзэж буй Шарын голын нүүрсний уурхайтай салшгүй холбоотой.

Шарын голын нүүрсний уурхайтай уншигч та 1981 онд бүтээсэн уурхайчдын ажил, амьдралын тухай өгүүлдэг “Гэрлэж амжаагүй явна” уран сайхны киноноогоор эчнээ танилууд билээ. Урлагийн гавьяат зүтгэлтэн Ж.Бунтарын найруулсан кинонд Шарын гол 1600 гаруй ажилтантай, жилдээ хоёр сая орчим тонн нүүрс олборлодог хөдөлмөр өрнүүн үе дүрслэгдсэн

байдаг. Өнөөдөр уурхайн захиргаа хүрэх зам дагуух шороон овоолгууд өвс ургамалд хучигдан, мод ургаж байгалийн унаган төрх нь юм уу гэж эндүүрэхээр болжээ. Хагас зууны түүх туршлагыг гэрчлэх мэт.

Тэгвэл 50 жилийн дараа гэхэд Шарын голын уурхай хувьцаат компани болж Монголын Хөрөнгийн бирж дээр хувьцаа нь эрэлттэй, ТОП-20 индекст багтлаа. Тус уурхай салбартаа шинэ үеийн хөгжлийн туршлага хуримтлуулж яваагийн нотолгоо энэ ажээ.

Анх уурхайн ордыг Зөвлөлтийн мэргэжилтнүүд илрүүлж 100 сая тонн нүүрсний нөөцтэй гэж тогтоосон байдаг. Харин 2003 онд төр өөрийн эзэмшиж байсан 80 хувийг хөрөнгийн захаар дамжуулан шилжүүлснээр уурхай 100 хувь хувийн өмч болж. Энэ үед уурхайн машин, техник хуучирч хоцрогдсон, хөрс хуулалтын ажил муу хийгдсэнээс ил уурхайн шаталсан ханууд эгцэрч, олборлолтын хэмжээ 2010-2011 оны үед 300 мянган тонн болтлоо буурсан байна. Уурхайн үйл ажиллагаа удаагүй зогсоно гэсэн хүлээлт үүсч, тогтоосон нөөц ч шавхагдаж байлаа. Харин 2010

оноос АНУ-ын “Firebird management” хөрөнгө оруулалтын сан тус компанийн хувьцааг ихээр худалдан авч, улмаар компанид хөрөнгө оруулалт хийв. 2010-2013 онд 5.1 сая ам.доллараар лицензийн талбайд нэмэлт хайгуул хийснээр тус уурхайн сэргэлт эхэлжээ. Хайгуулын ажлын үр дүнд олон улсын JORC стандартын дагуу үндсэн уурхайн нөөцийг 71.8 сая тонн гэж тогтоосон бөгөөд үүнээс гадна 124.4 сая тонн нүүрсний нөөц бүхий “Шаазгайт” ордыг илрүүлэн баталгаажуулсан байдаг. Энэ үр дүнг Монголын эрдэс баялгийн зөвлөл хянаж үзээд одоо ашиглаж буй технологиор 191 сая тонныг нь олборлож, ашиглах боломжтой гэсэн дүгнэлт хийжээ.

“Шарын гол” ХК хөрөнгө оруулалт татсанаар машин, тоног төхөөрөмжүүдээ шинэчилж, хөрс хуулалтын ажлыг эрчимжүүлж чадсан байна. Ингэснээр олборлолт нэмэгдэж 2013 онд олборлолтоо бараг хоёр дахин “нугалж”, өнгөрсөн жилд 700 мянган тонныг гарган авснаар үйл ажиллагаа нь эргэн жигдэрч, 2014 оны ТОП-100 аж ахуйн нэгжид багтах

хүртэл амжилттай ажилласан байна. Харин энэ онд 900 мянган тонныг олборлох, дараа ирэх жилээс сая тонн хүргэх төлөвлөгөөтэй байгаа аж. Ирэх хоёр гурван жилээс олборлолтоо бүр 2.5 сая тоннд хүргэх зорилт өмнөө тавьжээ.

50 настай “Шарын гол” ХК үйлдвэрлэлийн шинэ үеийг эхлүүлэх гэж байна. Шарын голын нүүрс Монголын бусад уурхайнхтай харьцуулахад илчлэг чанар өндөр, шаталт сайтай гэдэг. Олборлож

буй нүүрсний дийлэнх нь 4900 ккал/кг давсан илчлэгтэй. Тийм ч учраас хүнд үйлдвэрүүд түүхий нүүрсийг нь авч ашигладаг. Тэгвэл компани нүүрснийхээ илчлэгийг сайжруулж 6000 ккал/кг хүргэхээр төлөвлөжээ. Үүнд хүрэх арга нь нүүрсийг баяжуулах бөгөөд жилдээ 600 мянган тонн нүүрс баяжуулах хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна. Английн “Parnaby Cyclones” хэмээх компанид үйлдвэрийн тоног төхөөрөмжийг захиалж хийлгэсэн

гэнэ. Тус компани нь бүх төрлийн ашигт малтмалын баяжуулалтын технологи үйлдвэрлэлээр мэргэшсэн, олон улсад танигдсан бөгөөд туршилт тохируулгын ажлаа ч өөрсдөө хариуцаж ажиллажээ. Харин гүйцэтгэл дээр Австралийн “JPCM” компанийн мэргэжилтнүүд ирж хяналт тавьсан байна. Туршилт тохиргооны явцад ямар ч асуудал гараагүй бөгөөд үйлдвэрийн ирээдүй гэгээлэг байгаа тухай тус үйлдвэрийн менежер Э.Мөнх-Оргил ийн ярьсан юм.



Нүүрс баяжуулах үйлдвэрийн менежер
Э.Мөнх-Оргил

-Үйлдвэр ашиглалтад орсноор нүүрсний чанарт ямар өөрчлөлт гарах вэ?

-Баяжуулах үйлдвэр барьсан зорилго маань дотоодын хэрэглэгчдэд сайн чанарын нүүрс нийлүүлэхээс гадна экспортын гарцыг нээх. Өөрөөр хэлбэл, төмөр замд холбогдсон давуу талаа ашиглан Орос, Солонгос, Япон руу экспортлох зорилготой. Үнийн хувьд мэдээж олборлолтын зардал дээр тодорхой өртөг нэмэгдэнэ. Одоогийнхоос илүү ашиг олох боломжтой.

Нүүрсний чанарын хувьд “ALS” олон улсын итгэмжлэгдсэн лабораторид түүхий болон баяжуулсан нүүрсний дээжийг шинжлүүлсэн. Тэгэхэд манай сайн чанарын нүүрсний илчлэг 6540 ккал/кг болсон. Тухайлбал, Хойд Солонгосын тавьж буй шаардлага 5500-6500 ккал. Гэтэл манай хамгийн муу чанарын нүүрсний илчлэг 6000 ккал/кг давж байгаа юм.

-Өрсөлдөх чадварын хувьд, ямар боломж байгаа вэ. Өмнөд, хойд хөрш өөрсдөө нүүрсний асар баялагтай шүү дээ?

-Хувьцаат компани, олон нийтэд нээлттэй, танигдсан гэдэг нь манай нэг давуу тал. Гарцаа бид нээчихсэн гэж үзэж

Э.Мөнх-Оргил: Хамгийн муу чанарын нүүрсний илчлэг 6000 ккал/кг давсан

байгаа. Зам, тээврийн яамны Далайн захиргаатай хамтарч ажилласны үр дүнд ОХУ-ын төмөр замаар дамжуулан далайн гарц нээхээр болсон. Мөн ложистикийн тээвэрт хамтарч ажиллах түнш маань зөвхөн тээвэрлэлт төдийгүй нийлүүлэлтийн асуудлыг давхар хариуцах санал тавьсан. Өөрөөр хэлбэл, бид олборлоод, баяжуулаад, түүнийгээ ачих үүрэг л хүлээх юм. Нүүрсээ баяжуулаад, нөөцөө бэлдчихвэл жилд 20 сая тонн хүртэлх экспортын зах зээл байгаа.

-Өргөжүүлэх боломж бий юу?

-Бид томоохон аж үйлдвэрүүдэд зориулсан сайн чанарын бүхэллэг баяжуулсан нүүрс, эрчим хүчний станцуудад зориулсан нунтаг баяжуулагүй нүүрс гэсэн хоёр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Тиймээс нунтаг нүүрсэд зориулан ахин өргөтгөл хийх боломжтой. Эхний ээлжинд баяжуулсан нүүрсээ борлуулж, хэрэглэгчдэд хүлээн зөвшөөрөгдсөний дараа өргөтгөл төлөвлөгөө бий.

-Хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдсэн бэ?

-Европын хөгжлийн банкнаас зээл авсан. Одоогийн байдлаар үйлдвэрийн бүтээн байгуулалтад 12 тэрбум төгрөг зарцуулаад байна.

Шарын голын уурхай хойд бүсийн буюу Эрдэнэт, Дарханы эрчим хүчний станцын хэрэглээг хангадаг. Нийт олборлосон нүүрснийхээ 75 хувийг эрчим хүчний хэрэглээнд нийлүүлдэг. Харин түүхий нүүрсний үнийг төрөөс өнөөдрийг хүртэл хязгаарласаар байгаа нь эрчим хүчний үйлдвэрүүдэд сөргөөр нөлөөлсөөр буйг бид мэднэ. Гэтэл нүүрс олборлох, тээвэрлэх зардал

нь олох орлогоосоо бараг давдаг аж. Ийм нөхцөлд компани ашигтай ажиллаж, өргөжих, тэлэх бололцоо хомс болдог талаар Монголын уурхайн удирдлагууд байнга ярьдаг. Хэрэв уурхайн үйл ажиллагаа тэлж, компани ашигтай байвал наад зах нь сум, орон нутгийн иргэд ажил орлоготой байх нь мэдээж. Тус компанийн ажилчдын 90 гаруй хувь нь Шарын гол сумын иргэд. Дээр нь

нүүрс баяжуулах үйлдвэр нээгдсэнээр 20-иод хүн ажлын байртай болжээ. Тэдний цаана 20 гэр бүл баталгаата орлоготой болсон гэсэн үг. Цаадахыг нь харвал уурхайг дагасан жижиг, дунд бизнесүүд бий болж Шарын голынхны хөгжилд нэмэр болох учиртай. Тухайлбал, өнгөрсөн өвөл уурхайн ажилчдын гутлыг сумынхаа үйлдвэрлэгчтэй гэрээ байгуулж, худалдан авсан байна.

Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулснаар компани эрчим хүчний зах зээлээс ихээхэн хамааралтай байдлаасаа гарч дээр дурьдсан сайн үр дагавар улам өргөн хүрээг хамрах үүд нээгдэж байгаа юм. Шарын голын баяжуулсан нүүрсийг импортлохоор ярилцаж байгаа БНАСАУ-ын Газар,

далайн тээврийн сайд Кан Жон Ван энэ оны гуравдугаар сард “Шарын Гол” ХК-д зочилж нүүрс баяжуулах үйлдвэртэй танилцжээ. Тэрбээр “Цаашид үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрч, экспортын чанартай нүүрсийг гадаад зах зээлд амжилттай гаргана гэдэгт итгэлтэй байна” хэмээн ярьсан нь энэ

үйлдвэрийн ирээдүйг нэлээд гэгээлэг төсөөлөлтэй болгож. “Шарын гол” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батбаатар “Одоо нээгдэж буй баяжуулах үйлдвэр нь ердөө нэгдүгээр үе шат. Цаашид үйлдвэрээ улам өргөжүүлж жилд хоёр сая тонн нүүрс борлуулах хэмжээнд хүргэх зорилготой” гэв.

Б.Батбаатар: Хэтийн зорилго жилд хоёр саян тонн нүүрс борлуулах

-Шарын голын уурхай 50 жилийн түүхтэй. Цаашид ахиад зуун жил ашиглах тухай ярьж байна. Уурхайн ирээдүйг юу гэж харж байна вэ?

- Жил бүр нэг сая тонн нүүрс олборлоно гэж бодоход 194 жил ашиглах нөөц байна. Тэгэхээр ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж сууна. Бусад уурхайтай харьцуулахад дэд бүтэц сайтай, төмөр замтай. 50 жилийн түүхтэй гэдэг утгаараа боловсон хүчний асуудал шийдэгдсэн, нүүрсний илчлэг чанар харьцангуй өндөр. Баяжуулах үйлдвэрээ бид нэгдүгээр үе шат гэж үзэж байгаа. Санхүүгийн боломжоо харж байгаад ирэх жилээс хоёрдугаар үе шатыг эхлүүлнэ. Хэтийн зорилго жилд хоёр сая тонн нүүрс борлуулах. Ингэхийн тулд жилдээ 2.5 сая тонн орчим түүхий нүүрс олборлох шаардлагатай.

Одоогоор манайд 430 орчим хүн ажиллаж байна. Ажилчдын тоо цаашид нэмэгдэнэ, сум орон нутгийнхнаас илүүтэй дэмжиж ажиллана.

-Төрийн өмчит компани байх, эсвэл бүгдийг хувьчлах ёстой гээд олон нийт эсрэг, тэсрэг байр суурьтай байдаг. Төрийн өмчит компаниудын хувьд менежмент муутай гэдэг. Шарын голын уурхай ч өмнө нь төрийн өмчит байсан. Таны бодлоор төрийн компаниуд юун дээр алдаж байна вэ?

-Дэлхий даяар л төрийн өмчит компаниудыг хувийн өмчит компаниудтай адил өндөр ашигтай ажиллаж чаддаггүй гэсэн шүүмжлэл байдаг. Аливаа компани ашгийн төлөө ажилладаг байхад төрийн өмчит компаниудын хувьд давхар бодлого хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Ингэснээр ашиг олох гол зорилгоосоо тодорхой хэмжээгээр гаждаг. Миний бодлоор төрийн өмчит компани байх ёстой. Тийм шаардлага байна. Гэхдээ бүх компанийг төрийн өмчит болгох ёстой гэвэл өрөөсгөл. Хувийн хэвшил байснаар өрсөлдөөн бий болно. Чанар, үйлчилгээ сайжирна.

Салбарынхаа хүрээнд ярихад Багануур, Шивээ-Овоо,

1980-аад оны Шарын голтой харьцуулахад өнөөгийн Шарын голын үйл ажиллагаанд “муу” дүн тавина. Харин таван жилийн өмнөхтэй харьцуулбал “үнэмлэхүй сайн” дүн авна. Ахин таван жил өнгөрөхөд түүхэн

амжилтаа шинэчлэнэ гэдэгт эргэлзэх зүйл үгүй ажээ. Уурхай хэзээ хаалгаа барих бол гэсэн айдас замхарч, 200 жил, магад түүнээс ч илүү урт хугацаанд ашиглах тэмүүлээр солигдож болох юм. Уурхайтайгаа нас чацуу энэ суманд



“Шарын гол” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батбаатар

Адуунчулуун манайхтай л адил эрчим хүчний салбарт нүүрс нийлүүлдэг компаниуд. Гэхдээ удирдлага нь төр. Хэрэв эдгээр компани хувийн хэвшилд очвол үйл ажиллагаа явуулахад хэцүү. Сүүлийн хэдэн жил алдагдалтай ажиллаж ирсэн. Төрийн өмчит болохоор л үйл ажиллагаа нь зогсолгүй явж байна. Энэ нь муу юу, сайн уу гэдгийг ганц ашгаар нь үнэлж болохгүй. Багануур, Шивээ-Овоо зогсвол өнөөдөр төвийн бүс эрчим хүчгүй болно шүү дээ.

-Баяжуулах үйлдвэр барьж буй зорилго нь юу вэ?

-Зорилго нь нүүрснийхээ чанарыг сайжруулж, тогтвортой нэг түвшинд барих. Манайх цахилгаан станцуудаас гадна Эрэл, Хөтөлийн цементийн үйлдвэр, Дархан төмөрлөг зэрэг үйлдвэрт нүүрс нийлүүлдэг. Цахилгаан станцуудын хувьд түүхий нүүрс хэрэглэх стандарттай. Эрэл, Хөтөлийн үйлдвэр хэдийгээр түүхий нүүрс хэрэглэж байгаа ч энэ нь бүтээмж бууруулдаг. Эрэлийн цементийн үйлдвэрээр жишээ авахад нүүрсээ нунтаг болгоод клинкер шатааж байгаа шүү дээ. Гэтэл түүн дотор шороо, чулуу орчихоор шаталт дутуу өгч, клинкерийн чанар нь мууддаг. Цаашлаад зуухыг нь гэмтээж хохирол учруулдаг. Гэтэл барилгын салбараа дагаад үйлдвэрлэл нь улирлын чанартай байдаг. Нэг удаа зуухаа зогсоож засвар хийхэд 2-3 долоо хоног алддаг гэж байгаа юм. Тэгэхээр нүүрс баяжуулах нь цаанаа бас эдгээр нарийн технологи ашиглаж байгаа байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зорилготой юм.

гурван үеийн уурхайчид амьдардаг. Эдүгээ дөрөв дэх үе нь номын дуу сонсч, боловсорч байна.

Тэд Шарын голын уурхайг ирээдүйд манлайлан авч явах хүч юм. ■



Бизнес стартапын
туршлага



Хууль эрх зүйн
зөвлөгөө



Хөрөнгө санхүүгийн
туслалцаа



Санхүүгийн иж бүрэн
үйлчилгээ



Маркетингийн
шийдэл



Ня-бо бүртгэлийн
дэмжлэг

Ажлын байрны түрээс

₮ 300K + НӨАТ

Дээрхээс гадна ширээ, сандал, уулзалт, сургалтын тасалгаа, интернет, дулаан, цахилгаан, ус, харуул хамгаалалт энэ үнэд багтаж байна.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж Өнгөт хэвлэл компанийн байр, 2-р давхар





ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Цахиур хагалагчид” айсуй

Б.Энхцэцэг

Хөгжингүй зах зээлтэй орнуудад хамгийн өндөр дүнтэй хөрөнгө оруулалтуудыг бизнес эрхлэгчид үнэт цаасны зах зээлээс босгодог. Харин манай улсад банкны үүд сахидаг.

“Санхүүгийн зах зээл нэг тулгууртай буюу банкнаас хэт хамааралтай байна. Тиймээс бодит эдийн засагт өгөх үр өгөөж нь төдийлөн хангалттай бус байна. Маш олон бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд банкны боломж, бололцоо төдийлэн хүрэлцэхгүй байгаа бөгөөд банкны зээлээр санхүүжилт босгох нь зардал өндөр, үр ашиг бага байдаг” хэмээн СЗХ-ны Үнэт цаасны зохицуулалтын газрын дарга Т.Гандулам хэлж, энэ нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх нь өнөөгийн бодит шаардлага гэж үзэж буйгаа хэлж байна.

Санхүүгийн салбарын нийт актив хөрөнгө 2014 оны эцсийн байдлаар 23.5 их наяд төгрөгт хүрээд байна. Үүний 96 хувийг банкны салбар дангаар бүрдүүлж байгаа бол үнэт цаасны зах зээл ердөө нэг хувийг эзэлж байна гэж Эдийн засгийн бодлого өрсөлдөх

чадварын судалгааны төвийн тойм мэдээлэлд бичжээ.

Тус төвийн мэргэжилтнүүд дээрх нөхцөл байдлыг “Энэхүү ганц тулгуурт тогтолцоо нь бизнес эрхлэгчид болон иргэдийн зээл, хөрөнгө оруулалтын хэрэгцээ хангах боломжит сонголтыг бууруулж байна. Банкны зээлээс бусад эх үүсвэрээр санхүүжилт олж авах нөхцлийг бий болгох хэрэгцээ өндөр байна” гэж мөн дүгнэжээ.

“Эдийн засгаа хөгжүүлэе гэхээр үйлдвэр барья гээд байгаа. Гэтэл бодит өрсөлдөх чадвартай үйлдвэр байхын тулд санхүүгийн салбар сайн хөгжих хэрэгтэй гэдгийг Хятад, Америк ойлгочихоод байна” хэмээн Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг хэлж байна.

Товчхондоо, хүсч буй санхүүжилтийг санхүүгийн салбар үйлдвэрүүд, үндэсний үйлдвэрлэгчдэд бий болгож өгдөг. Онолын үүднээс манайд хөрөнгө оруулалт хомс байна гэдэг санхүүгийн салбар сайн хөгжөөгүй, хөрөнгө оруулалтын сувгуудын хувьд сонголтгүй байгаа. Олон жил даатгал болон

хөрөнгийн зах зээл санхүүгийн салбарт хэр жижигхэн байр суурь эзэлж байгааг ярьж, хэлж хэлэлцэж ирлээ. Гэхдээ өдгөө зах зээлийн бодит шаардлага хаалга тогшиж, үүнд Монголын хөрөнгийн зах зээлийнхэн ч жинтэй хариу үйлдэл үзүүлэх шинжүүд илэрч байна.

Өдгөө Монголын Хөрөнгийн биржийн үнэлгээ 600 орчим сая ам.доллар буюу 1.1 их наяд төгрөг орчим. Биржид хэдэн жилийн өмнө Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтарч олон улсын стандарт бүхий технологийн шинэчлэлийг авчирсан. Энэ нь тус зах зээлийг хөгжүүлэхэд шаардагдах эхний алхам. Үүнийг хийж чадлаа. Гэхдээ энэ хангалттай юу гэвэл үгүй гэж эдийн засаг, бизнесийнхний төлөөлөл хэлж байв. Тэд үүнийг түлхэц хүчин зүйл нь байсан. Одоо илүү том алхмууд энэ салбарт хэрэгтэй гэгцгээж байна. Үнэт цаасны салбарын гол хууль шинэчлэгдэж, хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсан. Одоо холбогдох дүрэм журмуудыг цэгцэлж, хэрэгжүүлэх л үлдсэн байгаа. Харин тэдний хэлээд буй том алхмуудад шинэ бүтээгдэхүүн

бий болгох, худалдан авагчид зах зээд татах лавтай орох биз.

ШИНЭ ЖИМС

Хөрөнгийн захыг сонирхож буй хүн бүрийн толгойд бууж ирдэг асуулт нь “Энэ лангууны хоёр талд бүтээгдэхүүн ба худалдан авагч байна уу” гэдэг юм Санхүүгийн зохицуулах хороо худалдан авагчаа бэлдэх шаардлагын дагуу мэргэжлийн том хөрөнгө оруулалтын сангууд, менежментийн компаниудыг үйл ажиллагаанд оруулахад анхаарч ажиллаж байгаа аж. Худалдан авагч гэхээр л гаднын хөрөнгө оруулагч л орж ирэхгүй юм бол өөр боломж байхгүй мэт санадаг. Гэхдээ гаднынхан орж ирэхийн тулд эхлээд арилжаа дотоодынхоо хүчээр идэвхжих хэрэг бий. Үүнд томоохон сангууд нөлөөлөх учиртай. Дотоодод үнэт цаас худалдаж авах бололцоо байгаагийн нэг жишээ нь даатгал. Тухайлбал, цалингийнхаа 20 хувийг бид даатгалд төлж байгаа. Энэ нь жилдээ нэг их наяд төгрөг нийгмийн даатгалын санд хуримтлагдаж буй гэсэн үг. “Хамаг зардлаа хасаад 300 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээл рүү оруулахад ТОП 100 аж ахуй нэгжийн 3-4 ыг нь худалдаад авчихна” хэмээн Ө. Ганзориг хэлж байна.

Өдгөө Монголын ТОП 100 аж ахуй нэгжийн ердөө дөрөв нь л хувьцаат компани байгаа. Энэ бол дахиад 96 өөр төрлийн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн байна гэсэн үг. Гэхдээ тэднийг татан оруулж ирэх тийм ч амаргүй бололтой. Өдгөө банк бус санхүүгийн байгууллагуудын жилийн хүү 50 шахам хувь болчихоод байхад хөрөнгийн зах зээлд гарах сонирхол бизнес эрхлэгчдэд байгаа нь мэдээж.

Бизнес эрхлэгчдийн сонирхлыг өдөөх үүднээс Монголын хөрөнгийн бирж арилжааны шимтгэл болон бас бус компаниудаас авдаг байсан зардлуудыг багасгаж, бууруулах арга хэмжээ авсан. Мөн тэд бүртгэлийн 60 хоногийг 20 хоног болгож цөөлсөн аж. Үүний зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хороо зах зээл дэх мэргэжлийн байгууллагуудаа дэмжих үүднээс оролцогчдоос нийт орлогын 10 хувьтай тэмцэх үйлчилгээний хөлс авдаг байсан бол үүнийг 2017 он хүртэл 100 хувь чөлөөлсөн байна.

МХБ-ийн Гүйцэтгэх захирлын

үүрэг гүйцэтгэгч Д.Ангар “Бид бизнес эрхлэгчдэд тавьдаг өндөр босгыг бууруулсан. Өмнө нь хоёрхон самбартай байхад үндсэн хөрөнгө нь доод тал нь нэг тэрбум, дээд тал нь 10 тэрбум байх ёстой байсан. Мөн үйл ажиллагаа явуулсан жил нь гурван жил байх ёстой гэдэг байлаа. Ингэхээр иргэдийн дунд Хөрөнгийн бирж бол бидний биш том компаниуд л ордог газар гэх буруу ойлголт бий болчихсон байсан нь үнэн. Тэгвэл одоо гурав дахь самбартай болсноор тэнд гарааны компани ч орж ирэх боломжтой болж байгаа юм. Тэндээс хөрөнгө оруулагчид үнэхээр ашигтай төсөл байвал хөрөнгөө оруулаад явж болно” хэмээн хэлж байна.

Хөрөнгийн биржээр дамжуулж олон нийтэд хувьцаагаа зарсан компанийн бизнес хүмүүст бүх талаас ойлгоход илүү нээлттэй байдаг учир зээл, хөрөнгө оруулалт ч бусдаас илүү хялбар орж ирдэг. Гэхдээ өдгөө хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа 200 гаруй компанийг бүгдийг нь дээрх шалгуурууд дундуур ногоон гэрлээр зорчдог “онц” гэж хэлж боломгүй. Тиймээс Хөрөнгийн биржийн бүртгэлд их цэвэрлэгээ хийж буй аж. Өөрөөр хэлбэл, хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаггүй, хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлдэггүй компаниуд удахгүй биржийн бүртгэлээс хасагдах нь. Нэг талаас муугаа шахаад нөгөө талаас сайныг оруулж ирэх бодлогыг хөрөнгийн зах зээлийн бодлого тодорхойлогчид барьж байгаа аж.

Сайн бүтээгдэхүүн хөрөнгийн биржид оруулж ирэх нь нэн тэргүүний асуудал болчихоод байна гэж үзэх хүмүүс цөөнгүй. Гэвч хувийн томоохон компаниудын хувьд лав “цахиур хагалж” орж ирэхгүй нь бололтой. Тиймээс засаг дорвитой хөдөлж төрийн өмчит компаниудаа нэг, нэгээр нь зах зээл рүү оруулахээр зэхэж байна. Ингэж шийдлээ, удахгүй төр өмчөө хувьчилна гэсэн яриа цөөнгүй жилийн өмнөөс гарсан учир шинэ мэдээ биш байж мэднэ. Гэхдээ юуг, хэзээ, хэрхэн гэдэг асуултуудад хариулт олдлоо. Төрийн өмчит компаниудыг Монголын хөрөнгийн биржээр хувьчлах бэлтгэл ажлыг хангах, компани нэмж хувьцаа гаргах, гаднын бирж дээр давхар бүртгүүлэх тал дээр Японы Санхүүгийн хамтын ажиллагааны нийгэмлэг Жайка

Санхүүгийн зохицуулах хороо гурван жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж байна. Тус төсөл нь Японы Санхүүгийн зохицуулах хороотой манай улсын Санхүүгийн зохицуулах хороо хамтран ажиллах санамж бичиг зурсан тэр үеэс ажил хэрэг болох үндэс бүрдсэн юм.

2017 оны зургаадугаар сар гэхэд төслийн хугацаа дуусах бөгөөд төслийн үр дүнд 4-5 Төрийн өмчит компанийг биржээр арилжаалчихсан байх мөн 2-3 компанийг гадаадын хөрөнгийн бирж дээр бүртгүүлчихсэн байна хэмээн Үнэт цаасны зохицуулалтын газрын дарга Т.Гандулам хэллээ. Төслийн багын зүгээс “IPO” гаргах компаниудыг сонгож, үнэлгээ хийж, гадаадын бирж дээр давхар бүртгүүлэхэд олон улсын шаардлагыг хэрхэн хангаж, ямар бэлтгэл хийх ёстой вэ гэдэг дээр заавар зөвлөмж өгөх тал дээр холбогдох сургалтыг эхлүүлээд байна. Одоогоор компанийн сонголтыг хоёр тал хамтран хийж байгаа гэдгийг тэрбээр мөн хэлсэн юм.

Эхний компани ирэх оны эхний хагас жилээс хэтрэхгүй хөрөнгийн бирж дээр хувьцаагаа санал болгоно гэж холбогдох эрх бүхий байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаад байгаа аж. “Эдийн засгийн нөхцөл байдал болоод гадаад, дотоод хүчин зүйлүүдийг харна. Болж өгвөл богино хугацаанд IPO гаргах тал дээр ажиллана. Төрийн өмчийн хорооноос төрийн өмчит компаниудыг сонгох тал дээр саналыг нь авсан. Уул уурхай, эрчим хүч, цахилгаан холбоо зэрэг салбарыг хамруулсан компаниудыг сонголтод оруулж байгаа” хэмээн Т.Гандулам хэллээ.

Санхүүгийн салбарын хөгжил зохистой хэмжээнд байна гэдэг эдийн засгийн хөгжил илүү олон хүнд хүртээмжтэй байна гэсэн үг. Санхүүгийн салбарын утга учрыг бодитоор гаргах цаг нь болсныг Монголын эдийн засгийн өнөөгийн байдал илтгэж буй. “Монгол улсын Санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр” -ийг удахгүй УИХ-аар хэлэлцэнэ. Өмнө нь ийм бодлогын баримт бичгийг тус салбарт зориулан гаргаж байсан удаа байхгүй. Энэ нь баялгийг төр бус, санхүүгийн салбар тэгш тараадаг гэдгийг засаг ойлгож, хэрэгжүүлж эхэлсний шинж болов уу. ■

Д.Ангар: Хөрөнгийн биржийг хөдөлгөх төрийн бодлого шаардлагатай байна

Д.Бэхбаяр



Хөрөнгийн зах зээлийг хүчээр биш бодлогоор хөгжүүлэх ёстой

Хөрөнгийн зах зээлийн шинэчлэл, тулгамдсан асуудал, цаашдын хөгжлийн талаар Монголын Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангартай ярилцлаа.

-Монголын Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх шаардлагатай гэж сүүлийн хэдэн жил ярилаа. Дорвитой өөрчлөгдсөн зүйл алга. Учир шалтгаан нь юунд байна вэ?

-Нэгдүгээрт, ярихаас илүү Хөрөнгийн биржийг бодитой хөгжүүлэх нь улс орны хөгжлийн нэг гол түлхүүр гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Түүн дээрээ тулгуурласан дунд болон урт хугацааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх субъектүүдийг нарийвчилж зааж өгсөн хөтөлбөрийг гаргах шаардлагатай гэж би харж байгаа. Миний хувьд Хөрөнгийн биржид ирээд нэг жил болж байна. Иргэдийн хувьд Хөрөнгийн бирж, хөрөнгийн зах зээл гэхээр их хол сонсогддог. Ойлгомжгүй, төвөгтэй, мэддэггүй салбар гэх хэсэг байна. Арай жаахан мэдлэгтэй нь энэ угаас бүтэхгүй салбар гэнэ. Тэгэхээр Хөрөнгийн бирж хөгжлийн нэг түлхүүр болох нөхцлийг бүрдүүлмээр байна.

Тус байгууллагыг өөрчилж, шинэчилж гэх үг бол хангалттай гарсан, харин үйлдэл нь дутаад байна.

-Яг ямар үйлдлүүд хийх ёстой вэ. Монголд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого, хууль дүрэм байна уу?

-Нэгдүгээрт, цаасан дээр буусан хэзээ ч хэрэгждэггүй төлөвлөгөө, баримт бичиг шаардлагагүй. Харин төрөөс бодитой, дорвитой хоёроос гурван томоохон үйлдэл хийчихвэл энэ зах зээл хурдан сэргэх боломжтой. Учир нь энэ өөрөө олон нийтийн зах зээл. Тус зах зээлийг нэг л зөв замаар ажиллуулаад эхэлчихвэл хэн нэгэн хүн ирээд зогсооно гэж байхгүй. Зөв ажиллаж байгаа тохиолдолд Хөрөнгийн бирж улс төрөөс хараат бус болчихдог. Өөрөө өөрийгөө зохицуулаад явчихдаг зах зээл. Миний бодлоор 1990 онд томоохон хувьчлал явсан. Ягаан, цэнхэр тасалбар нь хөрөнгийн зах зээлийг хөдөлгөсөн нэг гол хүчин зүйл мөн байсан. Түүнээс хойш төрөөс энэхүү зах зээлийг ерөнхийдөө зөнд нь хаячихсан.

Хөрөнгийн биржийн захиралд том зах зээлийг ганцаараа хөдөлгөх хүчин

мөхөсдөнө. Үүнд төрийн оролцоо юу байх вэ гэхээр, дээр үед олон араанаас бүрддэг “баадуутай цаг” гэж байдаг байсан даа. Тэр цагны баадууг эхэлж эргүүлэх хүч хэрэгтэй. Нэг эргэхсэн тохиолдолд тэр цаг өөрөө эргээд ажиллана. Төрийн зүгээс Хөрөнгийн биржийн цагны эхний баадууг л хөдөлгөөд өгчихмөөр байгаа юм.

Үнэхээр Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийг зорьсон болтомоохон боломжууд арав, таван жилийн өмнө байсан гэж би хардаг. Нэгдүгээрт, төрөөс компаниудад маш их хэмжээний хөнгөлөлт, татаас өгдөг. Жишээлбэл, “Чингис бонд”-оос том үйлдвэрүүдэд санхүүжилт олгосон. Тэгвэл төр хөрөнгийн зах зээлээ хөгжүүлж, компаниудаа ил тод, нээлттэй, олон нийтийн компани болгоё гэдэг чин зорилттой байсан бол компаниудад шаардлага тавьж болох байсан. “Та нар хувьцаат компани бол, Хөрөнгийн биржид бүртгүүлээд ир. Хувьцаагаа олон нийтэд санал болго. Үүний дараа та нарын гаргасан бондыг худалдаж авъя, хөнгөлөлттэй зээл өгье гэдэг ч юм уу ийм бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй

байсан болов уу. Ийм шаардлагыг таван жилийн өмнө гаргасан бол өнөөдөр 5-10 үндэсний аж ахуйн нэгжүүд олон нийтэд нээлттэй, ил тод санхүүгээ тайлагнадаг, хариуцлагаа хүлээдэг, хувьцаат компани болох боломж нь байсан. Гэтэл өнөөдөр бүх компани хаагдмал хүрээнд ажиллаж байна. Хамгийн том компаниуд нь хаалттай компаниуд. Төрөөс өгч байгаа татаас нь нь ч хаалттай. Ийм орчинд хөрөнгийн зах зээл хөгжихгүй.

-“АПУ” тэргүүтэй хувийн компаниуд ХК л байгаа шүү дээ.

- АПУ Говь зэрэг Хөрөнгийн биржийн тэргүүлэх компаниуд бий. Гэхдээ эдгээр нь 1990-ээд оны цэнхэр, ягаан тасалбараар үүссэн л ХК-иуд. Харин ХХК байж байгаад хувьцаат болсон жинхэнэ утгаараа олон нийтийн томоохон компани манайд бараг байхгүй. Миний бодлоор MCS, МАК, Петровис гэх мэт үндэсний хувийн том компаниуд ХК байх ёстой гэж хардаг. Америкийн хамгийн том 100 компани нь Хөрөнгийн биржийнхээ хамгийн том, ТОП100 хувьцаат компани нь байдаг. Бусад улсад ч адилхан. Гэтэл Монголын хувьд хамгийн том 100 компани нь хувийнх, гэр бүлийн бизнесээр яваад байгаа. Үүнийг мэдээж хүчээр задална гэж байхгүй. Харин хувийн хэвшлийн компаниудад ХК болох хүслийг нь төрүүлэхийн тулд төр татаас, урамшуулал, хөнгөлөлт чөлөөлөлтийг ашиглах шаардлагатай. Тухайлбал, татвар. ХХК орлогын албан татвар 10 хувийг төлдөг бол ХК 9.9 хувийг төлнө гэх мэтчилэн хугацаа заагаад өгчихвөл том компаниуд хөрөнгийн зах зээлд нээлттэй орж ирэх нөхцөл бүрдэнэ. Үүнийг л төрийн дэмжлэг гээд байгаа юм.

Уг нь улс орны эдийн засгийн нөхцөл байдал, газрын доорх баялаг, гурван сая иргэний боловсролын түвшин зэргийг аваад үзвэл Монголын хөрөнгийн зах зээл дэлхийн хэмжээнд биш юм аа гэхэд, Азидаа өрсөлдөхүйц хэмжээний Хөрөнгийн бирж байх бүрэн боломжтой. Гагцхүү цагны баадууг л түлхэх төрийн хүч хэрэгтэй байна даа.

-Төрд хөрөнгийн бирж гэдэг цагны зүүг хөдөлгөх дорвитой бодлого байхгүй хэрэг үү?

-Төр эхний алхмыг хийх ёстой. Хөрөнгийн бирж бол өдөр тутмын

арилжааг зохицуулдаг л газар. Үүнээс гадна төрийн зүгээс хөрөнгийн биржээ хөгжүүлбэ гэдэг үг, үйлдэл хоёр нь нийцэж байх ёстой. Гэтэл ярихаас өөр үйлдэл гарахгүй байгаад л гол учир шалтгаан байна. Банкны системээр төрийн хэдэн их наяд төгрөг эргэлдэж байгааг хүн бүр мэдэж байна. Гэтэл Хөрөнгийн биржээр төрийн мөнгө эргэлдэх байтугай Засгийн газар нь өөрийн үнэт цаасныхаа дөнгөж 10 хувийг л зарж байна.

-Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтраад Монголын биржийг хөгжүүлээд өгнө гээд л хэдэн жил боллоо. Энэ чинь үйлдэл биш үү?

-Энэ бол нэг үйлдэл байсан. Харамсалтай нь үр дүн нь хангалтгүй байна. Том зорилт тавьсан боловч хэрэгжилтийнхээ шатанд гажуудал, алдаа гаргаад гурван жилийнхээ үр дүнг бид авч чадаагүй. Лондон бол үнэхээр зөв зорилт. Харин хэрэгжүүлж чадаагүй.

-Лондонтой хамтрах төсөл дээр манайхаас ч зардал гарсан. Тэгэхээр ямар ч үр дүн гарсангүй гэсэн үг үү?

-Тодорхой хэмжээний үр дүн бий. Ямар ч байсан бид хууль, эрхзүйн орчноо шинэчилж авсан. Лондонгийн биржтэй байгуулсан гэрээний гол зорилго дэлхийн хэмжээний хөрөнгийн биржтэй болох юм шүү дээ. Хөрөнгийн биржийн өмнөх захирал маань хүртэл зорилтоо бүрэн биелүүлсэн гээд ажлаа өгсөн. Гэтэл манай бирж өнөөдөр ямар байгаа билээ.

-Юун дэлхий вэ. Улсдаа ч сайн ажиллаж чадахгүй байгаа шүү дээ.

-Тиймээ. Монголдоо ч хүлээн зөвшөөрөгдөхгүй байна. Гүйцэтгэл нь ямар байгаа нь харагдаж байна. Шалтгаан нь Лондонгийн Хөрөнгийн бирж биш. Бид дэлхийн хэмжээний хөрөнгийн биржтэй больё гэж зорьчихоод хэрэгжүүлэх нөхцлийг нь бүрдүүлээгүй. Алдаагаа бид өөрсдөөсөө хайх ёстой. Дотоодын хэрүүл тэмцэл, үл ойлголцол, маргаан зөрчилдөөн нөлөөлсөн.

Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв гэж огт шинэчлэгддэггүй, гурван жилийн гэрээг гацаасан байгууллагуудын нэг нь энэ төв мөн. Үүнийг бол хэзээ нэгэн цагт гаргаж тавих нь зүйтэй. Лондонгийн Хөрөнгийн бирж дэлхийн хэмжээний байгууллага. Гэтэл тэднийг Монголд

орж ирээд 14 сая ам.долларын луйвар хийгээд хаяад явчихлаа. Лондонгийн бирж биднийг хулхидчихлаа, муу гэрээ болж, ажилладаггүй програм шахсан байна, бид юу ч үгүй үлдчихлээ, үндэсний аюулгүй байдал алдагдлаа гээд л цуу үг тараасан. Уг нь Лондонгийн Хөрөнгийн бирж ийм байгууллага биш юм шүү дээ. Дэлхийн хэмжээний байгууллага. Хэрэв тэд ийм зүйл хийсэн тохиолдолд Лондонгийн Хөрөнгийн биржийн бүх бизнес, нэр хүнд дэлхий даяар унана. Жилдээ тэрбум ам.долларыг цэвэр ашгаар олдог бизнес нь зогсоно. Бид л өөрсдөө тэгээд бодчихсон, түүндээ итгэчихсэн. Үүнийгээ хөөсрүүлчихсэн.

Миний хувьд Хөрөнгийн биржид орж ирснээр үүнийг ил гаргасан. Бид буруу бодож явж ирсэн байна. Лондонгийн Хөрөнгийн бирж дэлхийн санхүүгийн түүчээ байгууллага. Монгол Улсад хэзээ ч бохир зүйл хийхгүй. Асуудал нь бидэнд байна гээд дотоодын асуудлаа цэгцэлж, арилжаа эрхлэгчдийн холбоо, брокерууддаа зөв ойлгуулахаар ажилласан. Тийм ч учраас өнгөрсөн оны есдүгээр сарын 9-нд Лондонгийн бирж манайтай хамтран ажиллах гэрээгээ дахиад гурван жилээр сунгасан. Бид дэлхийн хэмжээний хөрөнгийн бирж болох дуусгаагүй зорилтоо хэрэгжүүлэхээр зорьж байгаа.

Сүүлийн нэг жилд брокерууд, хөрөнгийн биржийн хооронд хэрүүл, маргаан сонсогдоогүй байх. Ирэх долдугаар сарын нэгэнд Ерөнхий сайдын Их Британид хийх айлчлалыг тохиолдуулан Лондонгийн Хөрөнгийн бирж дээр Монголын хөрөнгө оруулалтын чуулганыг зохион байгуулах гэж байна. Энэ бол гэрээний ач тус.

-ТОП-20 индекс бий. Эдгээр 20 компани засаглалын хувьд дэвшилттэй, нээлттэй байж чадаж байна уу. Танай бирж энэ талд юу хийж байна вэ?

-Хөрөнгийн бирж дээр гарсан компани олон нийтийн статустай компани байдаг. Нэг захирлын мэдлийн хувийн компани биш. Үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод тайлагнадаг, хяналт тавьдаг, олон нийтийн компани байх ёстой. Манай Хөрөнгийн биржид ийм байдал алга. Хаагдмал түвшинд. Хоёр, гуравхан хүн нэг компанийн дийлэнх хувьцааг эзэмшдэг. Санхүүгийн үйл ажиллагаа нь төдийлэн нээлттэй биш. Ийм зах зээлд дэлхий битгий хэл



хэн ч итгэхгүй. Компани өөрөө сайн засаглалтай байж сайн үлгэр жишээ үзүүлнэ. Улмаар хөрөнгө оруулагчдад итгэл үүсч, компани ч өгөөжийг нь хүртэнэ. Нөгөө талаар шинэ компаниуд орж ирэх боломжийг нээж өгнө.

Хөрөнгийн бирж нь өөрөө бүх юмны сайн жишээ байх ёстой. Сүүлийн жилүүдэд хэдэн хаалттай компани ямар ч хяналтгүй явж ирсэн. ТОП 20 бол манай индекс. Энэ индексийг бүрдүүлдэг эдгээр компанид нэг шаардлага тавьж байгаа. “Та нар ТОП 20-д багтаж байгаа бол компанийн сайн засаглалтай, өөрөө өөрсдийгөө үнэлдэг, түүнийгээ олон нийтэд тайлагнадаг байх ёстой” гэж.

Компаниуд маань сурч эхэлж байна. Компанийн засаглалын үндсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд, дутагдаж байгаа зүйлээ ойлгоод дараагийн шатандаа хийж эхэлж байна. Үр дүн нь тодорхой хэмжээгээр бидэнд мэдэгдэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлдөө хараат бус гишүүдийг элсүүлэх нь нэмэгдэж ирлээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дүрмийн дагуу хийж, санхүүгийн мэдээллээ өөрсдийн вэбсайт дээрээ байрлуулж, Хөрөнгийн биржид ирүүлдэг болж байна. Энэ бол нэг дэвшил. Гэхдээ бидний гол зорилго энэ хэдэн компанитайгаа зууралдах

биш, Монголын томоохон компаниудыг оруулж ирэх явдал.

-Оюу Толгой, Тавантолгой гэх мэт томоохон компаниудыг тодорхой хувиа дотоодын бирж дээр гаргах хууль гаргасан шүү дээ. Энэ хууль хэр хэрэгжих боломж бүрдэж байна вэ?

-Нөгөө үг, үйлдэл зөрдгийн нэг жишээ. Ашигт малтмалын тухай хуульд Стратегийн орд газруудын 10 хувийг Монголын Хөрөнгийн биржээр арилжаалах талаар заачихсан. 2013 онд УИХ-ын тогтоол гарсан байдаг. Гэтэл хуулийг хэрэгжүүлээгүй л байна. Хууль гарсан бол дагаж мөрддөг баймаар. Цаашдаа стратегийн орд эзэмшигч 15 орд бүгдээрээ дотоодын биржид орж ирэх ёстой. Тэгж байж Монголын хөрөнгийн бирж дэлхийн хэмжээний хөрөнгө оруулагчдын сонирхлыг татна. Хэдэн хаагдмал төвлөрсөн хувьцаа бүхий жижиг компаниудтай байх юм бол хөрөнгө оруулагчдыг татаж чадахгүй.

-Монголын хөрөнгийн биржийг хувьчлах тухай ярьж байгаа. Хувьд очсоноор бирж хэр ажиллах бол?

-Хувьчлалын төлөвлөгөөг Засгийн газарт өргөн барьсан байгаа. Маш зүйтэй асуудал. Ер нь төр хамгийн муу менежер гэдгээ үг, үйлдлээрээ хүлээн зөвшөөрөх ёстой. Хувьчлалыг жинхэнэ шилдэг технологи, шилдэг менежмент, ноу-хау, шинэ тогтолцоо, үр ашиг гэж харах хэрэгтэй. Зүүн хувь төрийн өмчит Хөрөнгийн биржид гаднын томоохон хөрөнгө оруулагчид итгэхгүй.

Хөрөнгийн бирж өөрөө олон нийтийн хувьцаат компани байх ёстой. Хувьцаа эзэмшигчид нь хөрөнгийн биржийг дунд хугацаанд маш хурдтай хөгжүүлэх гадаад, дотоодын стратегийн хөрөнгө оруулагчид байх ёстой. Гэхдээ миний хувьд гадаадынхан давамгайлсан байгаасай гэж боддог. Яагаад гэвэл, өнгөрсөн 24 жил бид биржээ хөгжүүлж чадсангүй. Гаднын шилдэг менежмент, технологи, шилдэг ноу-хау, туршлага оруулж ирье гэж л байгаа бол гадаадын стратегийн хөрөнгө оруулагчид л ажиллах ёстой.

Би Монголын Хөрөнгийн биржийг хувьчилж авах хүсэлтэй дотоодын хоёр гурван хүн байдаг гэж сонссон. Гэхдээ тэр хүмүүсийн сонирхол нь бирж бус манай биржийн байр. Сүхбаатарын талбайн эргэн тойронд авч болох ганц үлдсэн төрийн өмч бол Монголын Хөрөнгийн биржийн байр гэж тэр хүмүүс харж байгаа бол тэр хүмүүсийг хувьчлалаас хол байлгаасай гэж бодож байна. Байрлал, байранд шунасан хүн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхгүй нь ойлгомжтой.

-Монгол Улсад банк болоод санхүү, хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг харахаар үнэхээрийн хол зөрөөтэй тоо харагддаг. 95:3:2 гээд. Энэ зөрүүг явал богино хугацаанд ойртуулах вэ?

-Гурван салбар байгаа. Хөрөнгийн зах зээл, банк, даатгал болон санхүүгийн бусад салбар. Энэ салбарууд дотроо Хөрөнгийн бирж хамгийн том нь буюу дор хаяж 40 хувийг эзэмшдэг байх ёстой. Одоо бол 95:3:2 харьцаатай. 95 хувь нь банк, гурван хувь нь хөрөнгийн зах зээл, үлдсэн нь бусад. Бусад дотор нь даатгал, бичил санхүү нь орсон. Тэгэхээр гурван хувийн хөрөнгийн зах зээл 40 хүртэл өсч байж эдийн засаг зөв хөгжинө. Монголын олонх компани өнөөдөр банкны барьцаанд орчихоод байна. Бүгд зээлтэй. Зээл нь богино хугацаатай, өндөр хүүтэй. Монголын бизнесүүд муу байгаадаа биш. Санхүүгийн систем нь гажуудалтай, гажуудалтай юм руу компаниудаа чихээд оруулчихаар компаниуд нь гажуудаж байгаа юм. Энэ гажуудлыг засахын тулд санхүүгийн системийг зөв гольдролд нь богино хугацаанд оруулах нь чухал.

Хөрөнгийн зах зээлийг хүчээр биш, бодлогоор хөгжүүлэх ёстой. Энэ зах зээл нь банкны системээ давж ирж байж өөрөө 40 хувь, банк нь 30 хувь, үлдэх 30 нь даатгал, бичил санхүүд байж эдийн засаг, санхүү зөв эргэлдэнэ. Аж ахуйн нэгжүүд, төр нь ч өөрөө урт хугацааны, бага хүүтэй бүтээн байгуулалтын санхүүжилт авдаг боломж нээгдэнэ. Тухайлбал, Засгийн газар өөрөө дотооддоо бонд гаргадаг. Харин үүнийг нь дөрөв таван банк л хуваажавдаг. Засгийн газар өөрөө тэр банкуудынхаа гарт орчихоод байгаа шүү дээ. Засгийн газар нь дөрөвхөн банкны хэмжээнд санхүүжилт босгож

байхад аж ахуйн нэгжүүд нь хэрхэн санхүүжилт босгох вэ. Тэгэхээр хүссэн хүсээгүй банкны зах зээлийг хүчээр задлах ёстой болно. Маш хэцүү, том асуудлуудтай тулгарна. Банкуудын эрх ашиг хөндөгдөнө. Төр, засгийн бодлого гаргагчид энэ асуудлыг алсын хараатай харах ёстой. Ийм эрсдлүүд байна. Ийм ажил хийгдэх юм байна. Гэхдээ дунд, урт хугацаандаа улсын хөгжилд хэрэгтэй гэдгийг ойлгох ёстой. Яг одоогийн байгаагаар явах юм бол бизнес, компани, улс хөгжихгүй.

-Харин сүүлийн үед бирж овоо ашигтай ажиллаад байгаа мэдээлэл байна. Та Монголын хөрөнгийн биржид ирснээр ямар тодорхой ажлууд хийсэн бол?

-Нэгдүгээрт, компанийн засаглал, хувьцаат компаниудыг ил тод байлгах дээр нэлээд анхаарч ажиллалаа. Компанийн засаглалыг шинээр гаргаж, хувьцаат компаниудад шаардлага болгож тавилаа. Хоёрдугаарт, "ТОП 20"-ын индекс нь тооцооллын гажуудалтай байсныг заслаа. Индекс гэдэг нь зах зээлд зөв илэрхийлж байж зөв мэдээ болж байх ёстой.

Хуучин ТОП 20 гэж индекс байсан

бол одоо MSE ALL буюу бүх хувьцаат компанийн мэдээллийг хамруулсан шинэ индекс гаргаж ирсэн. Мөн Засгийн газрын үнэт цаас байна. Хөрөнгийн бирж бүтээгдэхүүнгүй болсон байсан. Дэлгүүрээр яривал бор давснаас өөр юмгүй байсан гэсэн үг. Тэгвэл Засгийн газрын үнэт цаас буюу энгийнээр яривал цэвэр ус гэдэг бүтээгдэхүүн оруулж ирсэн. Жимс, зайрмаг гээд олон юм зарж болно. Цэвэр ус бол хүн бүрийн хэрэглэдэг зүйл. Гэтэл хүн болгоны хэрэгцээний цэвэр усыг зөвхөн банкинд зараад байсан байгаа юм. Энэ хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг оруулж ирж олон нийтийн арилжаа болголоо. Хүн цэвэр ус авахаар дэлгүүр рүү явна. Цэвэр усны хажууд жимс байвал нэг ус, нэг жимс авдаг болно. Дараа нь сүү. Сүүгээ тавьчихвал манай дэлгүүрт компаниуд сүүгээ нийлүүлж эхэлнэ. Энэ мэтчилэн Хөрөнгийн биржийг бүтээгдэхүүнтэй болгох талд ажиллаж байна.

Монголын Хөрөнгийн бирж фонд зарж чаддаггүй, өдрийнх нь арилжаа 5,10 сая төгрөгөөс хэтэрдэггүй гэх ойлголт байсан. 2015 он гараад өдрийн дундаж арилжаа хоёр тэрбум төгрөгт

хүрсэн. Сүүлдээ фонд маань эрэлтээ дийлэхээ болилоо. Хуучин зарагддаггүй байсан бол сүүлийн хоёр арилжаа дээр 115 тэрбум төгрөгийн захиалга ирлээ. Мөн бид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад зөв зохистой мэдээллийг нь өгч, тэдний итгэлийг сэргээхээр ажиллаж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гадаадын хөрөнгө оруулагч 20 хувиар нэмэгдсэн. Дотоодынх гэхэд хэдэн мянга дахин нэмэгдсэн. Бас нэг чухал зүйл бол Засгийн газрын үнэт цаас анх удаа зах зээлийн зарчмаар зарагдлаа. Дөрөвхөн банк бус, 500 орчим хүн Засгийн газрын фонд авчихаад байна. Цаашдаа мянга, хоёр, гурван мянга руу явна.

Түүнчлэн Засгийн газрын үнэт цаасны хоёр дахь зах зээл бий боллоо. Мөн БИНСЭ компани санхүүжилт татах зорилгоор нэмэлт хувьцаа гаргалаа. Энэ сардаа багтаад бас нэг компани корпорацийн фонд гаргахаар яригдаж байна. Энэ жилдээ 10 компанишинээр хувьцаа гаргах боломжийг нээснээр Хөрөнгийн бирж 2015 ондоо нэг их наяд төгрөгийн арилжаа хийх зорилт тавьсан. Зорилтоо үйлдлээрээ харуулахаар хичээн ажиллаж байна. ■

**ҮНЭТ ЦААСНЫ
ХАНШИЙН
МЭДЭЭЛЛИЙГ
ГАР УТАСНААСАА
АВАХ БОЛОМЖТОЙ
БОЛЛОО.**



Available on the
App Store

**2015 ОНД ӨДӨРТ
ДУНДЖААР 2.35
ТЭРБУМ ТӨГРӨГИЙН
ГҮЙЛГЭЭ ХИЙЛЭЭ.**



Year	Нийт арилжаа (Тэрбум төгрөг)	Өдрийн дундаж арилжаа (Тэрбум төгрөг)
2013	98.61	0.38
2014	60.36	0.24
2015	270.01	2.40

■ Нийт арилжаа ◆ Өдрийн дундаж арилжаа

Компанийн сайн засаглалын үлгэр жишээ “Говь”


Манай сэтгүүл ийм булан нээж байгаа бөгөөд энэхүү буланг Монголын Хөрөнгийн бирж хөтлөн явуулна. Булангийн анхны сэдвээр “ТОП-20” индекст багтах компаниудын засаглалын талаар мэдээлэх болно. Анхны салхийг “Говь” ХК-иар хагалав.

“Говь” ХК нь 1993 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэж, 7,801,125 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд арилжсан ба тус компанийн хувьцааг 16,554 иргэн аж ахуйн нэгж эзэмшдэг юм.

Олон улсын компанийн сайн засаглалын стандарт болох хувьцаа эзэмшигчдийн эрхийг дээдлэх болон тэдэнтэй адил тэгш харьцах зарчим, компанийн засаглалд оролцогч талуудын хүлээх үүрэг хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлж, нээлттэй ил тод байдлыг хангах зэрэг зарчмыг “Говь” ХК бодитоор амжилттай хэрэгжүүлж байгаа юм. Тус компанийн засаглалын кодексын хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

Хувьцаа эзэмшигчдийн хурал:

Тус компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг /ХЭХ/ жил бүрийн дөрөвдүгээр сард тогтмол хуралдуулж хэвшсэн. Олон жижиг хувьцаа эзэмшигчидтэй тул тэдний эрх ашгийг хамгаалах, мэдээллээр хангах, сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэхийн тулд ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын албан тушаалыг тусгайлан бүтцээрээ батлан ажиллуулдаг билээ. ТУЗ-ийн НБД нь ХЭХ ээлжит болон ээлжит бус хурлыг “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зар хүргэх журмын дагуу” олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж ХЭХ-ийн дэг, зохион байгуулалт, тооллогын болон редакцийн комиссыг ТУЗ-ийн хурлаараа шийдвэрлэн тушаал үйлддэг. Хувьцаа эзэмшигчдийн саналыг хурлаас өмнө шуудан, и-мэйлээр авах тухай зарладаг ба хурал дээр санал хураалтыг хуулинд заасны дагуу авдаг юм.



Борлуулалт

(Тэрбум төгрөг)

20.0	18.3	20.2	19.6	20.2	28.9	35.4	40.8	48.8	65.9
------	------	------	------	------	------	------	------	------	------

Нэгж хувьцаанд ноогдох ашиг

(төгрөг)

60	60	-	-	-	100	100	125	130	140
----	----	---	---	---	-----	-----	-----	-----	-----

Ногдол ашиг тараасан байдал:
“Говь” хувьцаат компани нь 1995 оноос өнөөдрийг хүртэл 14 удаа нийт 11,291,816,312.50 төгрөгийн ногдол ашгийг МХБ, “Говь” хувьцаат компани болон ҮЦТТХТ-өөр дамжуулан түгээсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ : Тус компанийн ТУЗ-ийн гишүүдийг ХЭХ-аар сонгосон ба нийт есөн гишүүний дөрөв нь хараат бус гишүүд байна. ТУЗ нь бизнес төлөвлөгөөг батлах, стратеги, бодлогыг тодорхойлон батлах, дотоод томоохон асуудлыг ТУЗ-ийн гишүүдийн хамтын хүчээр удирдаж хувь нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудын зохистой ашиг сонирхлыг хамгаалах, гүйцэтгэх удирдлагын багийг удирдлагаар хангаж чиглүүлж хувьцаа эзэмшигчдийн өмнө үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн тайлагнадаг.

ТУЗ-ийн дэргэд аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороотой ба аудитын хорооны харьяанд дотоод аудитын хэлтсийг 2011 онд байгуулсан. ТУЗ-өөс компанийн тухай мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг тогтмол хангах үүргийг тухайлан томилсон засаглалын ажилтан буюу Нарийн бичгийн дарга хэрэгжүүлдэг.

Нээлттэй ба ил тод байдал:

Олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг. Хяналтын тогтолцоог дотроо бүрдүүлж ажилладаг. Хөндлөнгийн аудитын компаниар өнгөрсөн онд

Deloitte Onch audit ХХК-г сонгон ажилласан.

Компанийн үйл ажиллагаа, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, хурлын шийдвэр, түүнийг нийтэд мэдээлэх МХБирж болон компанийн өөрийн цахим хуудсаар дамжуулан СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол мэдээлэх тухай” 505-р журмын дагуу боломжит мэдээллийг нийтэд мэдээлж хэвшсэн байна.

Хувьцаат компани нь үйл ажиллагаандаа засаглалын зарчмыг хэвшүүлэн өөрийн засаглалын төвшинг үнэлж, түүний хэрэгжилтэд зохицуулах эрх бүхий байгууллагын зүгээс хяналт тавин, заавар зөвлөгөө өгч, зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байх нь цаашид үнэт цаас гаргагчдын хөрөнгө оруулалт татах чадварыг дээшлүүлэхээс гадна нэр хүнд, цар хүрээгээ тэлэх төдийгүй Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэр болох юм.

МХБ-д бүртгэлтэй компаниудын засаглалыг сайжруулах үүднээс ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлэгч хувьцаат компаниудтай хамтын ажиллагааны тунхаг бичигт гарын үсэг зурж, хагас жил тутамд үнэлгээний ажлыг хийж эхлээд байгаа юм. “Говь” ХК нь МХБ-д бүртгэлтэй компаниудыг манлайлж шилдэг, сайн засаглалын үлгэр жишээ болж байна. ■

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн бирж



Most Money

ТӨЛБӨРИЙН НЭГДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

асуудлыг хэрхэн шийддэг вэ?



Г.ГАНХҮҮ Шар Айраг хамтлагийн дуучин

Би Most Money-ийн идэвхитэй хэрэглэгч. Жинхэнэ цогц байдлаар банкны бүх үйлчилгээг нэг дороос авч чаддагтаа талархдаг

Д.БАТСҮХ Номин Талст хамтлагийн дуучин

Саяхнаас Most Money-ийн хэрэглэгч болж хэрэглээний бүх төлбөрөө гар утсаараа хийж байна. Гар утас гэлтгүй вэбээр орж бүх үйлчилгээг авч болдог нь жинхэнэ COOL



Г.ТУЛГА Оюу Толгой ХХК

Би Өмнөговьд ажилладаг. Most Money ашигладаг болсноос хойш хотод байгаа хүн шиг л хотын байрныхаа мөнгийг төлж, хүүхдүүддээ пицца ч захиалаад өгчихдөг болсон. Мостолж амьдарья гэдэг хөөрхөн видео байна лээ. Тэрэн шиг л бүгдээрээ Мостолж амьдарья.



О.ДУЛАМСҮРЭН БОАЖНХЯам нягтлан бодогч

Би Мост-оор хөдөө байгаа аав ээждээ автоматаар сар болгон нэгж явуулдаг. Автоматаар гээд тохиргоо хийчихдэг болохоор их амар байдаг. Юм хөгжөөд сайхан байна даа.



Н.ЛХАГВАСҮРЭН АНУ-ын элчин сайдын яам

Дээр нэг хүн картгүйгээр АТМ-ээс мөнгө авахыг хараад би их гайхсан. Өмнө нь картаа мартаад мөнгөгүй хөглөснөө бодоод инээд хүрээд л тэр хүнийг хараад зогсоод байсан. Одоо бол би Most Money-ийн фэн нь болсон. АТМ дээрээс хугацаагүй хадгаламж, харилцах гээд ямар ч хамаагүй данснаасаа мөнгө авч болдог нь их зүгээр шүү.



Бүртгэл

Иргэний үнэмлэх, гар утастайгаа ХХБ, Капитрон банкны дурын салбар дээр очно уу.



Банкуудын өрсөлдөөний тойм

А.Бүрнээ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс Монголын банкуудын өрсөлдөөний тойм судалгааг гаргажээ. Санхүүгийн салбарын нийт актив өнгөрсөн оны эцсийн байдлаар 23.5 их наяд төгрөгт хүрээд байна. Үүний 96 хувийг банкны салбар дангаар бүрдүүлж буй аж. Өөрөөр хэлбэл, бизнесийн орчин, эдийн засгийн нөхцөл байдал банкны салбараас хараат хэвээр байгаа аж. Энэхүү ганц тулгуурт санхүүгийн тогтолцоо нь бизнес эрхлэгчид болон иргэд зээл, хөрөнгө оруулалтын хэрэгцээгээ хангах боломжит сонголтыг бууруулж буй. Санхүүгийн салбарт банкны зээлээс бусад эх үүсвэрээр санхүүжилт олж авах нөхцөлийг бий болгох хэрэгцээ өндөр байгааг судалгааны баг онцолжээ. Санхүүгийн салбарыг тодорхойлогч банкны салбарын нийт хөрөнгө 21 их наяд төгрөгт хүрсэн нь ДНБ-ий хэмжээнээс 4.5 дахин өндөр үзүүлэлт юм.

Олон улсын жишгээр хөгжингүй орнуудын банкны салбарын хөрөнгө ДНБ-ээсээ өндөр байдаг нь тухайн салбар харьцангуй сайн хөгжсөнийг илтгэдэг. Нөгөө талаар банкны салбар тухайн улсын эдийн засгийн тусгал болдог.

Манай улсын эдийн засаг өндөр өсөлттэй байсан 2011-2013 онуудад банкны салбарын нийт хөрөнгийн өсөлт жилийн 30-75 хувь байв. Харин өнгөрсөн оноос эдийн засгийн өсөлт саарсантай холбоотой тус салбарын өсөлт харьцангуй удааширч, улмаар 2015 онд хадгалагдах хандлагатай байгааг судалгаанд дурьджээ. Олон улсын байгууллагууд энэ оны эдийн засгийн өсөлтийг 3-5 хувь байхаар таамаглаад буй.

Тавдугаар сард Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын гэрээнд талууд гарын үсэг зурснаар эдийн засагт тодорхой хэмжээний эерэг хүлээлтийг үүсгэсэн. Түүнчлэн салбарын нийт актив энэ оны эхний улирлын байдлаар 21 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувь өссөн бол өмнөх улирлаас найман хувь буурчээ.

Банкны салбарын өсөлт 2014 оны эхний улирлаас эхлэн саарч, цаашид тогтворжих хандлагатай болоод байна. Энэ нь эдийн засгийн өсөлт удааширсан, Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр нөлөөний оргил үе шувтарсан, банкны хөрөнгийн үндсэн бүрдэл болох зээл олголт нэмэгдэхгүй байгаатай холбоотой аж.

Нийт зээл 12 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 8.6 хувь өссөн бол өмнөх улирлаас 1.9 хувь буурсан үзүүлэлттэй гарсан байна. Эдийн засгийн өсөлт удааширч бизнесийн орчны идэвхжил буурсан, зээлийн эрсдэл даах чадвартай иргэд, бизнес эрхлэгчдийн эрэлт буурсан зэрэг нь үүнд нөлөөлжээ.

Ипотекийн хөнгөлөлттэй зээлийг 2013 оны зургаадугаар сараас эхлэн олгосон бөгөөд энэ оны эхний улирлын байдлаар нийт 49 мянган иргэнд 2.2 их наяд төгрөгийн зээл олгожээ. Банкны салбарын үндсэн эх үүсвэр болох хадгаламж, харилцахын дүн 9.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс нэг хувиар өссөн бол өмнөх улирлаас зургаан хувиар буурчээ. Зээл ба хадгаламж, харилцахын харьцаа эхний улирлын байдлаар 126 хувь хүрээд байна. Банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ сайжирч байгаа ч зээл ба хадгаламж, харилцахын харьцаа

100 хувиас илүү гарч байгаа нь хөрвөх чадварын эрсдэл нэмэгдэх, банкууд эх үүсвэрийн дутагдалд орох эрсдэл байгааг сануулж байна. Түүнчлэн Монголбанкнаас арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх шийдвэр гаргаад байна. Энэ нь банкны системийн эрсдэл даах чадварыг сайжруулах эерэг нөлөөтэй.

Арилжааны банкуудын нийт активын 67 хувь нь том гурван банкинд төвлөрч байна. Үүнээс зах зээлд эзлэх байр сууриар ХХБ хамгийн их буюу зах зээлийн 25 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд активын хамгийн өндөр өсөлтийг Ариг банк үзүүлсэн бөгөөд хөрөнгөө 60 орчим хувиар өсгөж чаджээ.

Нийт харилцах ба хадгаламжийн 67 хувийг Том-3 банк, 27 хувийг Дунд-3 банк, үлдсэн зургаан хувийг бусад банкууд бүрдүүлж байна.

Эх үүсвэрийн хэмжээгээр ХААН банк тэргүүлж, ХХБ, Голомт банкууд удаалсан байна. Эх үүсвэр бүрдүүлэлтийн хувьд бусад ангилалд багтсан банкууд илүү хурдтай өсөлтийг үзүүлжээ. Тухайлбал, Ариг банк татан төвлөрүүлсэн хөрөнгөө 2.5 дахин нэмэгдүүлж чаджээ. Банкуудын нийт хөрөнгийн 72 хувь нь гурван том банкинд, 21 хувь нь дунд гурван банкинд, долоон хувь нь бусад банкинд байршиж байна.

Өөрийн хөрөнгийн дүнгээр ХААН банк тэргүүлсэн байна. Харин өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдаар Капитал банк тэргүүлж, ХХБ, Хасбанк удаалав. Түүнчлэн арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд энэ оны эхний улиралд нийт 78 тэрбум төгрөгийн ашигтай (татварын өмнөх) ажиллажээ. ■

ИНФОГРАФИК

Санхүүгийн салбарын бүтэц, мэргэжлийн оролцогчдын тоо, нийт активын хэмжээ /2015 оны нэгдүгээр улирлын байдлаар/



96%

Банк-14
Нийт актив-23
их наяд төгрөг



2%

ББСБ-378
Нийт актив-508
тэрбум төгрөг



0.3%

ХЗХ-159
Нийт актив-81
тэрбум төгрөг



1%



ҮЦ33-75
Нийт актив-156
тэрбум төгрөг



1%



Даатгал-17
Нийт актив-153
тэрбум төгрөг

Мөнгө, санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /Их наяд төгрөг/



Зах зээлд эзлэх хувь, активаар

Зах зээлд эзлэх хувь, өөрийн хөрөнгөөр



Зах зээлд эзлэх хувь, зээлээр



Зах зээлд эзлэх хувь, харилцах ба хадгаламжаар

Эх сурвалж: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв



Фотог: Б.Бямба-Очир

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Барилга өнөөдөр

Г.Түшээ

Барилгын салбарынхан “Энэ жилдээ манай салбар өөдлөхгүй нь. Сонгуулийн маргаашнаас л хөдөлгөөнд орж магадгүй” хэмээн ярилцаж сууна. Учир нь төр засаг хөдөлж, улсын эдийн засаг сэргэвэл энэ салбар хямралаас гарна гэх. Улсын бүтээн байгуулалтын ажилд 80 мянган хүн ажиллаж байгаа бөгөөд дагалдах салбарт 130 мянган ажлын байр бий болдог аж. Гэтэл эдийн засгийн хүндрэл энэ салбарт нөлөөлж, нийт ажилтны 40 гаруй хувь нь цомхотголд орсныг Монголын барилгын үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Түмэнжаргал хэлэв. Мөн дагалдах салбарт ажиллаж байгаа болон тэдгээрийн ар гэрийнхнийг тооцвол 300-

гаад мянган хүний орлого эрс буурах хандлага ажиглагдаж байгаа аж. Эдийн засаг энэ хэвээр үргэлжилбэл барилгын салбарт ихээхэн хүндрэл гарч, салбарын татвар төлөлт их хэмжээгээр буурч, барилгын материалын худалдааны байгууллагуудын хооронд өрийн сүлжээ үүсэх зэрэг хүндрэл үүсэхээр байгааг ч Г.Түмэнжаргал анхаарууллаа.

Харин Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч М.Батбаатар “Барилгын салбар бусад салбараа татах эрсдэлтэй. Амьдрал дээр улсын төсвийн ажлыг гүйцэтгээд мөнгөө авч, зээлээ төлж чадахгүй байдалтай байна. Манай салбарын бүтээн байгуулалт яваад л байна. Хөгжил зогссон юм

байхгүй” гэлээ. Барилгын компаниуд өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан ажиллаж байгаа ч барилга нь эргээд борлогдох нь хүнд байна.

Өнгөрсөн онд ашиглалтад орсон орон сууцны 7000 гаруй нь борлогдолгүй он дамжсан. Энэ онд 25 мянга орчим айлын орон сууц ашиглалтад орно гэж буй. Тэгэхээр зах зээлд 30 гаруй мянган айлын орон сууц байна гэсэн үг. Хэдий орон сууцны нийлүүлэлт хангалттай ч худалдан авалт муу байгааг салбарынхан ярьж байна. Тэдний хэлж буйгаар улсын эдийн засгийн “цусны эргэлт”-ийг сайжруулахын тулд дулааны улиралд барилгын салбарыг хөдөлгөөнд оруулах

хэрэгтэй гэнэ. Үүний тулд зах зээл дээр эзнээ хүлээж буй хэдэн мянган орон сууцыг борлуулах шаардлага тулгарна. Гэвч улсын хэмжээнд хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 1.8 хувь, чанаргүй зээл 0.5 хувийг эзэлж байгаа нь зээлийн чанарт 97.7 хувьтай буюу өндөр үзүүлэлт гэдгийг Ерөнхий сайд Ч.Сайханбилэг тодотгосон. Нэг үгээр, иргэдийн худалдан авах чадвар сул байгаа төдийгүй авсан зээлээ төлөх тэнхээ алга гэхэд хилсдэхгүй. Иймээс эдийн засгийн өнөөгийн байдалд төрөөс барилгын салбарыг дэмжих зайлшгүй шаардлага тулгарсныг албаныхан учирлаж байна. Эл асуудлаар Ерөнхий сайд “Засгийн газар энэ арга хэмжээний эхлэл болгон ипотекийн зээлийг тогтвортой, урт хугацаанд үргэлжлүүлэхийн тулд “Засгийн газрын Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-д урьдчилгаа төлбөрийн хэмжээг 10-30 хувь байхаар тусгасан ч 2013-2014 онд 30 хувиар хангагдаж ирсэн. Энэ төлбөрийн 20 хүртэл хувьд нь Засгийн газар баталгаа гаргаснаар банкны хувьд эрсдэлгүй, иргэд 10 хувийг төлөөд урт хугацаанд үлдсэн 20 хувийг төлөх боломж бүрдэнэ. УИХ бодлогын хувьд дэмжлэг үзүүлбэл Засгийн газар урьдчилгаа төлбөрийг бууруулах бололцоотой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” хэмээсэн.

Мөн тус зээлд хамрагдахад орон сууцны талбайн 80 ам.метр босгыг

чөлөөлж, нээлттэй болгоно гэж буй. Ипотекийн зээл олгож эхэлснээс хойш нийт 67612 иргэнд 2957.85 тэрбум төгрөгийн зээл олгож, 1657 иргэнд 57.75 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлжээ.

Энэ онд Барилга, хот байгуулалтын яамны зүгээс эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан салбартаа хоёр чиглэл барьж ажиллана гэдгийг салбарын сайд хэлсэн. Нэгдүгээрт, барилгын бизнесүүдээ дэмжинэ. Энэ хүрээнд захиргааны чанартай хүнд суртлын дарамтыг багасгаж, бизнес орчныг нь сайжруулахыг чухалчилж байгаа гэлээ. Мөн ипотекийн зээлийг үргэлжлүүлж, нөхцөлийг нь хөнгөвчлөх нөөц боломжийг эрэлхийлж буй. Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар “Энэ удаа эрэлт талаа түлхүү дэмжиж, санхүүжилтийн шинэ нөөц боломжуудыг судалж, хөөцөлдөж байна. Дотоодын нөөц боломж нэгэнт нимгэрсэн тул гадаадын хөрөнгө оруулалтыг татахад ач холбогдол өгнө” хэмээв. Хоёрдугаарт, эл салбарын урт хугацааны ерөнхий хөгжлийг бодолцсон алхмуудыг хийнэ гэж байна. Ингэхдээ салбарынхаа хөгжлийг “хүн-хэрэглэгч төв”-тэй болгохыг зорьж байгаа аж. Хүн төвтэй болгоно гэдэг нь хэрэглэгчийг дээдлэх, ажиллагсдын аюулгүй байдлыг эрхэмлэх, ард иргэдийн аюулгүй байдлыг хүндэтгэх гэсэн гурван зарчимд тулгуурлах юм байна.

Барилгын салбарын ирээдүйг төсөө-

лөхөд улсын эдийн засгийн байдалтай холбож үзэх хэрэгтэйг салбарынхан хэлж байна. Жилдээ л энэ салбарын хөрөнгө оруулалт 4.4 хувиар өссөн гэх тоо барим бий. Хөрөнгө оруулалт хийгдээд байгаа хэрнээ хөгжихгүй байна гэх асуудал урган гарч ирж байгаа юм. Харин орон сууцны зах зээлд сүүлийн хоёр жилд 4.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийнхэн хийсэн судалгаа байна. Салбар хөгжихийн хэрээр хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа гэсэн үг.

Гүйцэтгэж байгаа барилга угсралтын ажлыг жилийн хэмжээнд нь аваад үзэхэд 2001 оноос хойш дунджаар 10-15 хувиар өссөн үзүүлэлт байх. Хувийн хэвшлийнхний оруулж буй хөрөнгө оруулалт нэлээд хувийг эзэлж байна. Гэвч хөрөнгө оруулагчид барилга бариллаа гэхэд эргээд тэд худалдан авалтын батгалгаад эргэлзэж байгааг Монголын барилгын үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал хэллээ. Нөгөө талаас, зарим төслийн барилгын ажилд хөрөнгө оруулалт нь цаг алдаж ордог, мэргэжлийн боловсон хүчин дутмаг зэрэг нь саад болдог аж.


Хөрөнгө оруулалт, санхүүжилт талаас нь харахад хөгжил удааширсан мэт харагдаж байгааг Монголын барилгачдын холбооны Ерөнхийлөгч М.Батбаатар ярьсан. Гэхдээ салбарынхан өөрсдийн бололцоондоо бүтээн байгуулалтын ажлаа явуулсаар байгаа аж.

Барилгын нийт төслийг ашиглалтад орох хугацаанаас нь хамааруулан үзвэл 52 хувь буюу 19024 айлын 68 нь ашиглалтад орсон, 43 хувь буюу 22070 айлын 56 нь энэ ондоо ашиглалтад орохоор байгаа бол таван хувь буюу 1472 айлын зургаан төсөл ирэх онд ашиглалтад орохоор төлөвлөжээ. Энэ оны хоёрдугаар улиралд 21 төслийн 4350 айлын орон сууц ашиглалтад орох төлөвтэй байна. Гэвч барилгын ажлын явц, Улсын комиссын акт удааширах зэргээс шалтгаалан хойшлох тохиолдол багагүй байдаг байна.



ОН	УЛИРАЛ	ТӨСЛИЙН ТОО	АЙЛЫН ТОО	ЖИГНЭСЭН ДУНДАЖ ДҮН
2015	2015 ОНЫ II УЛИРАЛД	21	4350	2230.776
2015	2015 ОНЫ III УЛИРАЛД	17	8625	2.057.631
2015	2015 ОНЫ IV УЛИРАЛД	19	9095	2.468.080
2016	2016 ОНД	6	1472	3.645.805


Баригдаж буй барилгуудын ашиглалтад орох хугацаа, төсөл, айлын тоо



Өнгөрсөн сарын 5-ны байдлаар нийслэлийн долоон дүүрэгт 130 төслийн 42566 айлын орон сууц борлуулагдаж байна. Эдгээрээс хамгийн хямд үнэтэй нь Налайх, Баянзүрх дүүрэгт, хамгийн өндөр үнэтэй орон сууц бүсчлэл зэрэглэлээсээ хамаарч Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт худалдаалагдаж байна.

ХАНУУЛ ДҮҮРЭГ	2 847 164
СҮХБААТАР ДҮҮРЭГ	2 434 542
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ	2 350 000
БАЯНГОЛ ДҮҮРЭГ	2 259 098
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ	2 247 713
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ	1 680 722
НАЛАЙХ ДҮҮРЭГ	1 222 826


ШИНЭ ОРОН СУУЦНЫ НЭГ АМ МЕТРЫН ДУНДАЖ ҮНЭ /САЯ ТӨГРӨГ/



Орон сууцны үнийн индекс сүүлийн зургаан сарын турш агшилттай гарч, энэ оны эхний таван сарын байдлаар орон сууцны борлуулалт 27 орчим хувиар буурсныг “Тэнхлэг зууч” ХХК мэдээлсэн. Орон сууцны үнийн индекс өнгөрсөн тавдугаар сард 16.8 хувь болж, өмнөх сараас 0.2 хувиар өссөн. Харин өнгөрсөн оны мөн үеэс 5.4 хувиар агшчээ. Шинэ орон сууцны үнийн индекс 26.7 хувь болж, сарын дүнгээрээ 0.4 хувиар буурсан бол жилийн дүнгээрээ 0.5 хувиар өсчээ. Шинэ орон сууцны ам.метрийн дундаж үнэ 2.2 сая төгрөг байна.

Хуучин хоёр өрөө байрны дундаж үнэ энэ оны тавдугаар сарын байдлаар 94 сая 300 мянган төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.2 хувиар буурчээ. ■

ХУУЧИН ХОЁР ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /САЯ ТӨГРӨГ/



Эх сурвалж: barilga.mn, “Тэнхлэг зууч” ХХК

ДЭД БҮТЭЦ

Төмөр замын ХӨГЖИЛ

Ц.Элбэгсайхан



Төмөр замын нэгдсэн сүлжээ ашиг-лалтад орсноор томоохон ордыг үр дүнтэй ашиглах үндсэн нөхцөл болж өгнө

Монгол Улс зэс болон коксжих нүүрсний нөөцөөр дэлхийд 10,12 дугаар байрт ордог. Гэвч бүтээгдэхүүнүүдийг олон улсын зах зээлд гаргах дэд бүтэц хөгжөөгүй байгаа билээ. Иймд ашигт малтмалыг олон улсын зах зээл, хилийн чанад дахь зах зээлд хамгийн үр дүнтэйгээр буюу өрсөлдөхүйц хямд өртгөөр, их хэмжээтэйгээр тээвэрлэн хүргэх дэд бүтэц хэрэгтэй болж байна. Далайд гарцгүй улс орны хувьд хамгийн тохиромжтой шийдэл нь төмөр замын тээвэр. 2010 оны зургадугаар сарын 24-ний өдөр УИХ-ын тогтоолоор “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ыг баталж 5600 км төмөр замын сүлжээг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Шинэ төмөр замын бодлогын зорилго нь Монгол Улсын уул уурхайн салбарыг дэд бүтцийн хөгжлийн үйл явцтай уялдуулан, эдийн засгийн хувьд үр ашигтай байлгах. Харин хэрхэн уялдуулж, дэмжих талаар шийдвэр гаргагчид нэлээд удаан хугацаанд хэлэлцсэний дүнд өргөн, нарийн царигийг чиглэлээс хамааран тавих шийдэлд өнгөрсөн жил хүрсэн. Тухайлбал, “Арц суурь-Эрдэнэт”, “Тавантолгой-Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан”, “Хөөт-Нөмрөг” чиглэлийн төмөр замын шинэ шугамыг өргөн царигтай барих бол “Шинэ төмөр зам” төслийн Ухаа худаг-Гашуунсүхэйт, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замыг нарийн царигтай байхаар шийдвэрлэсэн. Энэ нь өмнийн говьд буй өндөр илчлэгтэй коксжих нүүрсийг дэлхийн хамгийн том худалдан авагч БНХАУ-ын стандартад нийцүүлж, богино хугацаанд, хямд зардлаар экспорлох боломж бий болгож байгаа хэрэг.

Бодлогыг хэд хэдэн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. I, II үе

шатны буюу эхний 1800 орчим км төмөр замыг “барих-ашиглах-шилжүүлэх” тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон юм. Нэгдүгээр үе шат гэдэгт “Сайншанд-Баруун Урт” чиглэлийн 350 км, “Баруун Урт-Хөөт” чиглэлийн 140 км, “Хөөт-Чойбалсан”-гийн 150 км зам барих ажил орж байгаа. Тэгвэл хоёр дахь үе шатад “Нарийн сүхэйт-Шивээхүрэн” 45.5 км, “Ухаа худаг-Гашуун сүхэйт” 267 км, “Хөөт-Тамсагбулаг-Нөмрөг”-ийн 380 км, “Хөөт-Бичигт” чиглэлийн 200 км зам барина. 1800 орчим км төмөр замын суурь бүтцийг барьж байгуулахад урьдчилсан тооцоогоор 6-8 тэрбум ам.доллар шаардлагатай гэж буй.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ

Төмөр замын нэгдсэн сүлжээ ашиг-лалтад орсноор зөвхөн тээврийн зардлыг бууруулаад зогсохгүй БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч экспортын шинэ гарцуудыг бий болгож чадах юм. Өөрөөр хэлбэл, манай улс ашигт малтмалын нөөц, идэвхгүй байгаа ордуудаа ашиглах, улмаар хилийн чанадад гаргаж олон улсын үнэ тарифаар худалдан авагчдад түгээх зорилго биеллээ олно. Тавантолгойн орд газрыг ашиглах цаашилбал Нарийн сүхэйт, Хөөт, Тамсагбулаг зэрэг ашигт малтмалын томоохон ордыг үр дүнтэй ашиглах үндсэн нөхцөл болж өгнө.

Нэг, хоёрдугаар үе шатны төмөр замуудын чиглэлийг ашиглалтанд оруулж, түүгээр олох орлогоороо баруун чиглэлийн төмөр зам буюу гуравдугаар үе шатны төмөр замын сүлжээг барьж ашиглах боломж нээгдэнэ. Ингээд Монгол Улс өөрсдийн мэдлийн бүрэн төмөр замын сүлжээг стратегийн орд

газрууд болон томоохон төслүүдтэйгээ холбосноор Аж үйлдвэрийн парк байгуулж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүнийг олон улсад гаргах, эдийн засгийн томоохон үр өгөөжтэй алхам хийгдэх юм. Шинэ төмөр зам баригдсаны дараа 5000 орчим ажлын байр бий болно гэсэн тооцоо бий. Зөвхөн Ухаахудаг-Гашуунсүхэйт чиглэлийн төмөр замын хувьд авч үзвэл ашиглалтад орсноор хилийн боомт хүрэх нүүрсний экспортын тээврийн зардал тонн тутамд 10 ам.доллараар буурах бөгөөд жилд 30 сая тонн хүртэлх хэмжээний экспорт хийх аж. Монгол Улс 2011 онд шороон замаар автомашинаар нүүрсээ тээвэрлэж 22 сая тонн нүүрс хилээр гаргасан нь хамгийн ихэд тооцогддог.

Шинэ төмөр замын бодлогын бас нэгэн зорилго нь байгаль орчинд ээлтэй байдлаар уул уурхайн салбарыг дэмжих. Урьд нь олон тооны шороон замаар хүнд даацын автомашинууд тасралтгүй сүлжилдэж байсан нь орон нутгийн хүн ам, ан амьтдын хувьд амьдрах орчин нөхцлийг доройтуулж байсан. Харин төмөр зам ашиглалтад орсноор бэлчээр сүйтгэх, тоосжилт, хөрс болон агаарын бохирдлын асуудал үлэмж хэмжээгээр багасах ажээ. Одоогоор Ухаа худаг-Гашуунсүхэйт чиглэлийн төмөр замын барилгын газар шорооны ажлын гүйцэтгэл 86.6 хувьтай байгаа бөгөөд энэ нь уг чиглэлийн бүтээн байгуулалтын нийт ажлын 51.84 хувь юм.

Энэхүү бүтээн байгуулалтад “Чингис” бондын хөрөнгөөс эхний ээлжийн санхүүжилт 200 сая орчим ам.доллартай тэнцэх төгрөгийг олгосон. Урьдчилан тооцоолж буйгаар цаашид 800 орчим сая ам.долларын санхүүжилт шаардлагатай ажээ. ■

ФИФА БА ГЭМТ ХЭРЭГ

Б.Энхмөнх



Сепп Блаттер /FIFA-гийн ерөнхийлөгч/

Өнгөрсөн тавдугаар сарын 27-нд Швейцарийн цагдаагийн алба Цюрихийн нэгэн тансаг зэрэглэлийн зочид буудлаас “FIFA”-гийн долоон дээд албан тушаалтныг баривчилснаас хойш дэлхийн хөлбөмбөгийн удирдах байгууллагад авлигын хэргийн дуулиан дэгдээд байгаа билээ.

Долоон эрхмийг АНУ-ын Хууль зүйн департаментын тушаалаар саатуулж буй бөгөөд Холбооны мөрдөх товчооны мөрдөн байцаалтаар одоо ажиллаж буй болон ажиллаж байсан нийт 14 албан тушаалтанд авлигын хэрэг үүсгээд байгаа юм.

“FIFA” нь дэлхийн хөлбөмбөгийн үйл ажиллагааг удирддаг байгууллага. Уг байгууллага сүүлийн жилүүдэд авлигын хэрэгт удаа дараа холбогдох болсон. Ялангуяа 2022 оны хөлбөмбөгийн ДАШТ-ийг зохион байгуулах эрхийг Персийн булангийн жижиг боловч баян, эрх мэдэл бүхий Катар улсад өгсөн нь шүүмжлэлд өртөөд буй. 2014 оны арванхоёрдугаар сард “FIFA” байгууллага дотроо хийсэн авлигын хэргийн шалгалтын талаар зарлахгүй байхаар шийдэж, оронд нь ДАШТ-ийн тендерийг хэвээр үлдээх болсон талаар тайлагнасан юм. Хөлбөмбөгийн ДАШТ нь дэлхийн хамгийн олон хүн үздэг спортын арга хэмжээ бөгөөд Олимпын наадмаас даруй хэд дахин илүү олон хүн үздэг аж. Тэр утгаараа ч ивээн тэтгэгч компаниуд, нэвтрүүлэх эрх болон бусад наймаанаас олон

тэрбум ам.долларын ашиг олдог. Энэхүү баривчилгаа, мөрдөн байцаалт “FIFA”-г ДАШТ-ийг зохион байгуулах эрх, ерөнхийлөгчийн сонгууль болон хөрөнгийн хуваарилалт, тэр дундаа “FIFA”-гийн буурай гишүүн орнуудад хуваарилах хөрөнгө ил тод шударга байдаг эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа аж.

ЯАГААД АЛБАН ТУШААЛТНУУДЫГ ЯЛЛАСАН БЭ?

Холбооны мөрдөх товчоо “FIFA”-г сүүлийн гурван жилийн турш шалгаж байсан аж. 2019 оны ДАШТ-ийг зохион байгуулах эрхийг ОХУ-д, мөн 2022 оны эрхийг Катар өгсөн нь мөрдөн байцаалт эхлэх шалтгаан болсон хэдий ч сүүлийн 20 жилийн хугацаанд хийсэн ажлуудыг нь шалгах шаардлага гарсан байна. АНУ-ын Хууль зүйн департаментын хэлж буйгаар авлигын уг хэргүүд АНУ-д болоогүй ч тус улсад төлөвлөгдсөн гэж үзэж байгаа аж. Түүнчлэн мөрдөн байцаалтаар уг хэрэгт холбоотой мөнгийг АНУ-ын банкуудаар дамжуулан шилжүүлсэн байх магадлалтай гэжээ.

АНУ-ын Нью-Йорк хотын Холбооны шүүхэд танилцуулсан 47 удаагийн хэргээр 12 шүүгдэгчийг яллаж байгаа төдийгүй тэднийг 24 жилийн туршид олон улсын хөлбөмбөгийн холбоог ашиглан авлигын замаар айлган сүрдүүлэлт, мэдээллийн луйвар хийж мөнгө угааж өөрсдийгөө хөрөнгөжүүлсэн гэж буй.

Хэрэгт холбогдсон гол этгээдүүдийн нэг болох Хойд болон Төв Америк, Карибын хөлбөмбөгийн холбооны (Concacaf) Ерөнхий нарийн бичгийн дарга асан Чарьз “Чак” Блайзер АНУ-ын прокуроруудтай хэрэгт хамтран ажиллахыг зөвшөөрөөд байгаа юм.

Тэрбээр хэлэхдээ 2004-2011 оны хороонд түүний бие болон “FIFA”-гийн бусад гүйцэтгэх хорооны зарим гишүүн 2010 оны ДАШТ зохион байгуулах эрхийг Өмнөд Африк улсад өгөхөд хахууль авах талаар тохиролцсон, мөн түүний хамтран хуйвалдагчдын нэг 1998 онд Морокко улсад хахууль авч Францад дэлхийн аваргыг зохиоход нөлөөлсөн гэв. Үүнээс гадна Блайзер болон бусад хэрэгт холбогдогч 1996, 1998, 2002 болон 2003 оны “Concacaf”-ийн Алтан Цомын тэмцээнийг нэвтрүүлэх эрхтэй холбоотой авлига авсан болохоо хүлээн зөвшөөрчээ. Харин 2010 оны ДАШТ-ийг Өмнөд Африкт зохион байгуулахын тулд 10 сая ам.долларын авлига өгсөн хэрэг АНУ-ын прокуроруудын анхаарлыг хамгийн ихээр татаж байгаа гэлээ.

Өмнөд Африкийн нэгэн сонин хүлээн авсан онлайн мэдээллээр уг тохиролцоог Өмнөд Африкийн Ерөнхийлөгч Табо Мбеки болон “FIFA”-гийн ерөнхийлөгч Сепп Блаттер хийсэн гэжээ. Уг и-мэйлд “FIFA”-гийн ерөнхий нарийн бичгийн дарга Жером Валке Өмнөд Африкийн нэгэн сайдаас Блаттер болон ерөнхийлөгч Мбеки

нарын өмнө тохиролцсон мөнгийг хэзээ шилжүүлэх боломжтой талаар асуусан байжээ. Харин Өмнөд Африкийн Засгийн газар уг мөнгийг Карибын хөлбөмбөгийн дэмжихийн тулд өгсөн хууль ёсны төлбөр хэмээн эсэргүйцэж байгаа ч “ВВС” агентлагын олсон бичиг баримтуудаас үзэхэд “FIFA”-гийн дэд ерөнхийлөгч асан Жэг Уорнер уг төлбөрийг бэлэн мөнгө хэлбэрээр авч хэрэглэн мөнгө угаасан байх магадлалтай талаар мэдээлсэн байна.

ХЭН БУРУУТГАГДАЖ БАЙГАА ВЭ?

АНУ-ын хэрэгт буруутгагдаж буй дээд тушаалтнууд Хойд Америк, Латин Америк, Карибын тэнгисийн хөлбөмбөгийн эрх мэдэл бүхий зуучлагчид байгаа юм. Тэд “FIFA”-гийн дор үйл ажиллагаа явуулдаг “Concasaf” буюу тухайн бүс нутгийн хөлбөмбөгийн үйл ажиллагааг хариуцдаг байгууллагатай холбоотой ажилладаг байжээ. Тэдний хийдэг байсан гол зүйл нь ДАШТ-ийг телевиз болон ивээн тэтгэх хэлэлцээрийг хийхэд оролцдог байсан аж. “Concasaf”-ийн ерөнхийлөгч Жеффри Уэббийг Сепп Блаттерийн залгамжлагч хэмээн үзэж байгаа. Түүний өмнө тус байгууллагын ерөнхийлөгчийн албыг хашиж байсан Жэк Уорнерийг уг хэрэгт мөн ялласан. Жэк Уорнерийг “FIFA” залилангийн хэргээр шалгаж эхэлснээс үүдэн албан тушаалаасаа огцорч өдгөө Жеффри Уэбб томилогдон ажиллаж байгаа юм.

Өмнөд Америкийн хөлбөмбөгийн холбооны (Conmebol) ерөнхийлөгч асан Николас Леоз болон Южинио

Фигуэрэдо нараас эхлээд Латин Америкийн хөлбөмбөгийн дээд албан тушаалтнууд ч уг хэрэгт холбоотой хүмүүсийн тоонд багтаж байна.

Уэбб, түүний шадар туслах Костас Таккас, Фигуэрэдо, Эдуардо Ли (“FIFA” болон “Concasaf”-ийн гүйцэтгэх гишүүн), Хулио Роха (“FIFA”-ийн хөгжлийн ажилтан), Рафаел Эскивэл (“Conmebol”-ийн гүйцэтгэх гишүүн), болон Хосе Мария Марин (Бразилийн хөлбөмбөгийн холбооны ерөнхийлөгч асан) нар Швейцарт баривчлагдсан бөгөөд тэднийг АНУ-руу шилжүүлэх ийг хэрэгтнүүд эсэргүүцэж байгаа аж.

Харин “FIFA”-гийн дэд ерөнхийлөгч асан Жэк Уорнер Тринидад улсад батлан даалтад гарсан бөгөөд АНУ-руу шилжүүлэгдэх өдрөө хүлээж буй гэх.

Спортын маркетингийн компанийн ерөнхийлөгч Алехандро Бурказо Италид гэрийн хорионд байгаа бол “Concasaf”-ийн ерөнхий нарийн бичгийн дарга асан Чак Блайзер тэргүүтэй дөрвөн хүн хэрэгт буруутай нь аль хэдийн тогтоогджээ.

ХЭР ИХ МӨНГӨНИЙ АСУУДАЛ ЯРИГДАЖ БАЙНА ВЭ?

Маш их. АНУ-ын яллаж буйгаар АНУ болон Өмнөд Америкийн нөлөө бүхий этгээдүүд 150 сая ам.доллараас дээш хэмжээний мөнгийг олон улсын хөлбөмбөгийн тэмцээний хэвлэл мэдээлэл, маркетингийн эрхийг авахын тулд хээл хахууль өгсөн мөн өгөх гэж төлөвлөж байсан гэв. Уг тоонд дэлхийн бусад оронд сэжиглэгдэж буй авлигын хэргүүд багтаагүй аж.

“FIFA” бараг л бүх орлогоо ДАШТ-аас олдог. Өнгөрсөн жилийн ДАШТ-ийг зохион байгуулахын тулд Бразил дөрөв орчим тэрбум ам.доллар зарцуулсан ч “FIFA” ойролцоогоор хоёр тэрбум ам.долларын ашгийг тэмцээний ивээн тэтгэгчид болон тэмцээн дамжуулах эрх, бусад худалдаа наймаанаас олсон байдаг. Дараагийн хоёр дэлхийн аваргын тэмцээнийг зохион байгуулах зардлын дэргэд энэ тоо юу ч биш бололтой. Жишээ нь, 2022 оны ДАШТ-ийг зохион байгуулах Катар улс зургаан тэрбум ам.долларыг зарцуулах төлөвтэй байгаа юм.

СЕПП БЛАТТЕР ЯАХ ВЭ?

“FIFA”-гийн ерөнхийлөгчид ямар нэг ял оноогоогүй байна. Тэрбээр уг хэргийг үл тоож буй төдийгүй хэрэг болсноос гуравхан хоногийн дараагаар “FIFA”-гийн ерөнхийлөгчийн албыг дахин дөрвөн жил хашихаар дахин сонгогдсон юм. Гэвч хэдхэн өдрийн дараа албан тушаалаа ойрын хэдэн сарын дотор хүлээлгэн өгөх болсноо мэдэгдлээ.

Үүний зэрэгцээ тэрээр “FIFA”-д шинэчлэл хийхээр ажиллаж байгаа гэж хэлжээ. 2018 болон 2022 оны ДАШТ хэрхэх нь гол асуулт болж байна. АНУ өмнө нь үйлдэгдсэн авлигын хэргийг илүүтэй шалгаж байгаа. Харин Холбооны мөрдөх товчоо болон Швейцарийн мөрдөх байгууллага одооноос эхлэн уг тэмцээнүүдийн зохион байгуулах эрхийг хэрхэн өгсөн талаар шалгаж эхлээд байгаа юм.

ОХУ-д болох 2018 оны ДАШТ-ийг эрхийг түтгэлзүүлж өөр улсад зохион байгуулах эрхийг өглөө гэж бодоход ийм богино хугацаанд цэнгэлдэх хүрээлэн барьж, дэд бүтцийг шийдэж, арга хэмжээг зохион байгуулах мөнгө хуваарилаж чадах улс байхгүй л болов уу. Тэр ч байтугай хөлбөмбөгийн эх орон болох Англи улс хүртэл цэнгэлдэх хүрээлэнгүүддээ шинэчлэл хийх хэрэг гарах гэнэ. Харин хамгийн бололцоотой хувилбар бол 2006 оны ДАШТ-ийг зохион байгуулсан Герман улс гэгдэж байна. Харин Катарийн хувьд эрхээ алдах магадлал тун өндөр болжээ. Тэд зохион байгуулах эрхийг авснаас хойш цагаач ажилчидтай эрх тэгш бус харьцдаг, мөн авлига өгсөн гэх дуулиан шуугиан гараад байгаа юм. ■

